




БИЗНЕС ЭРХЛЭЛТ БА

ЖЕНДЭР

2023





ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО



БИЗНЕС ЭРХЛЭЛТ БА ЖЕНДЭР 2023

Үндэсний статистикийн хорооны Аж ахуйн нэгжийн
2021 оны тооллогын дүнд суурилав.

Улаанбаатар
2023 он

ННА 65.290-2




ДАА 650

О-634

ТАЙЛАН БИЧСЭН:

Б.Лакшми	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн Ерөнхий захирал, Докторант
Э.Тунгалаг	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн Судлаач
Д.Оюунбилэг	Үндэсний статистикийн хорооны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын Бизнесийн бүртгэл, тооллогын хэлтсийн дарга
Г.Нарангэрэл	Зөвлөх, Монгол Улсын Их Сургуулийн Улс төр, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын тэнхимийн Докторант
Др.Б.Анхбаяр	Зөвлөх, Митчелл сангийн Жендэрийн тэгш байдлын судалгааны хөтөлбөрийн зохицуулагч

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

-  Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу
Засгийн газрын III байр
-  1900-1212
-  www.nso.mn, www.1212.mn
-  information@nso.mn

Тайлангийн дизайн, өгөгдлийн дүрслэлийг Тунгаахуй өгөгдлийн урланд бүтээв.

ISBN 978-9919-9907-3-2

ӨМНӨХ ҮГ

Үндэсний статистикийн хороо (ҮСХ) Монгол Улсын Статистикийн тухай хуульд заасны дагуу Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогыг амжилттай зохион байгуулж, үр дүнг танилцуулаад байгаа билээ. Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллого нь бизнес эрхлэгчдийн цогц мэдээлэл бүхий өгөгдлийн санг бий болгох үндсэн зорилгоо хангахын зэрэгцээ бизнесийн өгөгдлийг хүйсээр ангилан бүрдүүлснээрээ онцлогтой.

Энэхүү судалгааны тайлангаар Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогын хүйсээр ангилсан буюу аж ахуйн нэгжийн захирлын хүйсээр ангилсан үр дүнг сэдэвчлэн танилцуулж байна. Мөн тооллогын мэдээллийн сан болон УБЕГ-ын Хуулийн этгээдийн мэдээллийн санг нэгтгэх замаар аж ахуйн нэгжийн эзэмшигчийн нэг хүйсээр ангилсан өгөгдлийг бүрдүүлж, харьцуулан судалсан.

Аж ахуйн нэгжийн тооллогын өгөгдлийг хүйсээр ангилан бүрдүүлж, энэхүү судалгааны тайланг боловсруулахад Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ны "Төв Азийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүд" хөтөлбөр дэмжин ажиллалаа. Энэхүү хөтөлбөр нь Тажикстан, Киргизстан, Узбекистан, Монгол улсуудад нэгэн зэрэг хэрэгжиж, Төв Азийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэхэд дэмжин, техникийн туслалцаагаар ханган ажиллаж байна.

ЕСБХБ-ны тус хөтөлбөрийн хүрээнд мөн ҮСХ-ноос санаачлан Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санхүүгийн санаачилга (We-Fi), Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ)-тэй хамтран 2022 оны 5-р сарын 18-нд хүйсээр ангилсан жендэрийн статистик мэдээлэл бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх туршлага солилцох Бүс нутгийн цахим семинарыг амжилттай зохион байгуулсан. Семинарт Монгол, Гүрж, Молдав, Ирланд 4 улсын статистикийн байгууллагууд хүйсээр ангилсан статистик мэдээлэл бүрдүүлэх туршлагаа солилцож, мэдээлэл хуваалцан, үр дүнтэй түншлэлийг бий болгох эхлэл тавигдсан. Цаашид жендэрийн статистикийг улам боловсронгуй болгох, бусад байгууллагын мэдээллийн сантай уялдуулах зэргээр хүйсээр ангилсан статистикийг өргөжүүлэх чиглэлээр бид анхааран ажиллах болно.

Судалгааны тайланг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн ЕСБХБ-ны "Төв Азийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүд" хөтөлбөр, тайлан бичсэн ЭЗБӨЧСТ-ийн судлаачид болон ҮСХ-ны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын ажилтнуудад талархал илэрхийлье. Мөн тайлангийн дизайн, өгөгдлийн дүрслэлийг бүтээсэн Тунгаахуй өгөгдлийн урлангийн хамт олонд талархал илэрхийлж байна.

Судалгааны үр дүн цаашид нарийвчилсан жендэрийн дүн шинжилгээ хийх болон бизнесийн орчныг сайжруулах жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөр боловсруулахад ашиглах чухал эх үүсвэр болно гэж итгэж байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА
Б.БАТДАВАА

АГУУЛГА

1	БИЗНЕС ЭРХЛЭЛТ БА ЖЕНДЭРИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ	21
2	БИЗНЕС ЭРХЛЭЛТ БА ЖЕНДЭР	29
3	БИЗНЕСИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХ БА ЖЕНДЭР	55
4	БИЗНЕС ДЭХ УР ЧАДВАР БА ЖЕНДЭР	77
5	ТЕХНОЛОГИ, ИННОВАЦ, СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ БА ЖЕНДЭР	93
6	БИЗНЕСИЙН ТӨЛӨВ, ХАНДЛАГА БА ЖЕНДЭР	113

ӨМНӨХ ҮГ	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	6
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	11
УДИРТГАЛ	12
ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	14
ХУРААНГУЙ	16

1.1	Жендэр ба жендэрийн бодлогын тухай	22
1.2	Жендэрийн мэдрэмжтэй бизнес эрхлэлтийн бодлого	24
1.3	Бизнес эрхлэлтийн жендэрийн статистик	25

2.1	Бизнес эрхлэлтийн үндсэн үзүүлэлт	30
2.2	Бизнес эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн жендэрийн ялгаатай байдлыг хэмжих нь	38

3.1	Бизнесийн орлого бүрдүүлэлт ба жендэрийн ялгаатай байдал	56
3.2	Бизнесийн санхүүжилт, хөрөнгө оруулалт ба жендэрийн ялгаатай байдал	68

4.1	Ажлын байран дахь жендэрийн ялгаатай байдал	78
4.2	Дундаж цалингийн жендэрийн ялгаатай байдал	88

5.1	Технологи ашиглалт ба жендэрийн ялгаатай байдал	94
5.2	Инновац нэвтрүүлэлт ба жендэрийн ялгаатай байдал	100
5.3	Судалгаа хөгжүүлэлт ба жендэрийн ялгаатай байдал	106

6.1	Бизнес эрхлэхэд тулгарч буй бэрхшээл ба жендэрийн ялгаатай байдал	114
6.2	Ковид-19 цар тахлын нөлөө ба жендэрийн ялгаатай байдал	118
6.3	Бизнесийн төлөв, хандлага ба жендэрийн ялгаатай байдал	122

ДҮГНЭЛТ	124
ЗӨВЛӨМЖ	128

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

1. БИЗНЕС ЭРХЛЭЛТ БА ЖЕНДЭРИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Зураг 1. Судалгааны хамрах хүрээ	14
Зураг 2. Бизнесийн хүйсээр ангилсан ангилал	15

2. БИЗНЕС ЭРХЛЭЛТ БА ЖЕНДЭР

Зураг 3. Тооллогод хамрагдсан нийт ААН-ийн тоо, тооллого явагдсан оноор.....	30
Зураг 4. МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, хариуцлагын хэлбэрээр, 2021 он.....	31
Зураг 5. МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, 2021 он	32
Зураг 6. Үйл ажиллагаа явуулаагүй МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, шалтгаанаар, 2021 он	33
Зураг 7. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, бүсээр	33
Зураг 8. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, өмчийн хэлбэрээр	34
Зураг 9. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагааны чиглэлээр	34
Зураг 10. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаа явуулж буй хугацаагаар.....	35
Зураг 11. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, ажиллагчдын тооны бүлгээр.....	36
Зураг 12. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, борлуулалтын орлогын бүлгээр...	37
Зураг 13. МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, дүнд эзлэх хувиар, 2021 он	39
Зураг 14. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, хариуцлагын хэлбэрээр, захирлын хүйсээр, дүнд эзлэх хувиар	40
Зураг 15. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, өмчийн хэлбэрээр, захирлын хүйсээр, дүнд эзлэх хувиар.....	40
Зураг 16. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, хариуцлагын хэлбэрээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	41
Зураг 17. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, өмчийн хэлбэрээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	41
Зураг 18. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, бүсээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	42
Зураг 19. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, аймаг, нийслэлээр, захирлын хүйсээр, дүнд эзлэх хувиар	43
Зураг 20. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, салбараар, захирлын хүйсээр, дүнд эзлэх хувиар	46
Зураг 21. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, салбараар, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар	47

Зураг 22.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, салбараар, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	48
Зураг 23.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, ажиллагчдын тооны бүлгээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	49
Зураг 24.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, борлуулалтын орлогын бүлгээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	50
Зураг 25.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаа явуулж буй хугацаагаар, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар	51
Зураг 26.	Бизнес эрхлэгчид гэж хэн бэ?	52

3. БИЗНЕСИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХ БА ЖЕНДЭР

Зураг 27.	2020 онд үйл ажиллагаа явуулсан ААН-ийн нийт борлуулалтын орлого, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр	57
Зураг 28.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, борлуулалтын орлогын бүлгээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	58
Зураг 29.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, борлуулалтын орлогын бүлгээр, салбараар, эрэгтэй захирлаар, дүнд эзлэх хувиар.....	60
Зураг 30.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, борлуулалтын орлогын бүлгээр, салбараар, эмэгтэй захирал, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	61
Зураг 31.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаа явуулж буй хугацаагаар, борлуулалтын орлогын бүлгээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	62
Зураг 32.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг байрны эзэмшлээр, захирлын хүйсээр, дүнд эзлэх хувиар	64
Зураг 33.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, борлуулалтын орлогын бүлгээр, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг байрны эзэмшлээр, захирлын хүйсээр, дүнд эзлэх хувиар.....	65
Зураг 34.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг эсэхээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр.....	67
Зураг 35.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, зээл авсан эсэхээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар	69
Зураг 36.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан зээлтэй ААН-ийн тоо, ажиллагчдын тооны бүлэг, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	70
Зураг 37.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан зээлтэй ААН-ийн тоо, борлуулалтын орлогын бүлгээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	71
Зураг 38.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан зээлтэй ААН-ийн тоо, зээлийн эх үүсвэрээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, давхардсан тоогоор, дүнд эзлэх хувиар	72
Зураг 39.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, зээлэнд хамрагдаагүй шалтгаанаар, давхардсан тоогоор, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, давхардсан тоогоор, дүнд эзлэх хувиар	73
Зураг 40.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, гадаадын хөрөнгө оруулалттай эсэхээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар	74
Зураг 41.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийн хувь, гадаадын хөрөнгө оруулалтын хувиар, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар	75

4. БИЗНЕС ДЭХ УР ЧАДВАР БА ЖЕНДЭР

Зураг 42.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын тоо, ажиллагчдын хүйсээр.....	78
Зураг 43.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын тоо, ажиллагчдын хүйс, захирлын хүйс, эмэгтэй эзэмшигчээр.....	79
Зураг 44.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, ажиллагчдын тооны бүлгээр, салбараар, эрэгтэй захирлаар, дүнд эзлэх хувиар.....	80
Зураг 45.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, ажиллагчдын тооны бүлгээр, салбараар, эмэгтэй захирал, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	81
Зураг 46.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын тоо, ажиллагчдын хүйс, захирлын хүйс, эмэгтэй эзэмшигчээр.....	82
Зураг 47.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын тоо, ажиллагчдын хүйс, захирлын хүйс, эмэгтэй эзэмшигчээр, бүсээр.....	83
Зураг 48.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын хүйсийн харьцаа, бүсээр.....	84
Зураг 49.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын хүйсийн харьцаа, ААН-ийн хариуцлагын хэлбэрээр.....	85
Зураг 50.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан эрэгтэй захиралтай ААН-ийн нийт ажиллагчдад эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын эзлэх хувь, салбараар.....	86
Зураг 51.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан эмэгтэй захиралтай ААН-ийн нийт ажиллагчдад эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын эзлэх хувь, салбараар.....	87
Зураг 52.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын дундаж цалин, ажиллагчдын хүйс, захирлын хүйсээр, мянган төгрөг.....	89
Зураг 53.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын дундаж цалин, ажиллагчдын хүйс, захирлын хүйс, ажиллагчдын тооны бүлгээр, мянган төгрөг.....	90
Зураг 54.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын дундаж цалин, ажиллагчдын хүйс, захирлын хүйс, борлуулалтын орлогын бүлгээр, мянган төгрөг.....	91

5. ТЕХНОЛОГИ, ИННОВАЦ, СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ БА ЖЕНДЭР

Зураг 55.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан, үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг ААН-ийн тоо, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	94
Зураг 56.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаандаа компьютер тогтмол ашигладаг ажиллагчдын хувиар, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	95
Зураг 57.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг хувиар, ажиллагчдын тооны бүлэг, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр.....	96
Зураг 58.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг хувиар, борлуулалтын орлогын бүлэг, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр.....	97
Зураг 59.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаандаа сүлжээ ашигладаг эсэхээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	99
Зураг 60.	2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаандаа интернэт	

тогтмол ашигладаг эсэхээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	99
Зураг 61. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, өгөгдлийн сантай эсэхээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	99
Зураг 62. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, дата сервертэй эсэхээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар	99
Зураг 63. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, 2018-2021 онд шинээр эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг нэвтрүүлсэн хувиар, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр	100
Зураг 64. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан, бизнесийн үйл явцын инновац нэвтрүүлсэн ААН-ийн тоо, инновацын төрлөөр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, давхардсан тоогоор, дүнд эзлэх хувиар	101
Зураг 65. 2018-2021 онд шинээр эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг нэвтрүүлсэн МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, салбараар	102
Зураг 66. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн инновацын үйл ажиллагааны 2020 оны зардал, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, тэрбум төгрөг.....	104
Зураг 67. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан нэг ААН-д ногдох инновацын үйл ажиллагааны 2020 оны зардал, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, сая төгрөг.....	105
Зураг 68. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан, 2018-2021 онд судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар.....	106
Зураг 69. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан, 2018-2021 онд судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, салбараар, давхардсан тоогоор.....	107
Зураг 70. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын тоо, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр	108
Зураг 71. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын 2020 оны зардал, тэрбум төгрөг, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр.....	108
Зураг 72. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан нэг ААН-д ногдох судалгаа хөгжүүлэлтийн ажлын 2020 оны зардал, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, сая төгрөг	109
Зураг 73. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан нэг ААН-ийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын 2020 оны зардлын борлуулалтын орлогод эзлэх хувь, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр.....	109
Зураг 74. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан, 2018-2020 онд судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, захирлын хүйсээр, салбараар.....	110
Зураг 75. 2020 онд үйл ажиллагаа явуулсан, ISO стандартыг нэвтрүүлсэн МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, захирлын хүйсээр, салбараар.....	110
Зураг 76. 2020 онд үйл ажиллагаа явуулсан, тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, захирлын хүйсээр, салбараар.....	111
6. БИЗНЕСИЙН ТӨЛӨВ, ХАНДЛАГА БА ЖЕНДЭР	
Зураг 77. Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ 2020 оны эхний 9 сартай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн бэ?	114
Зураг 78. Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгжийн орлого 2020 оны эхний 9 сартай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн бэ?.....	115

Зураг 79. Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгжийн хэрэглэгчдийн захиалгын хэмжээ 2020 оны эхний 9 сартай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн бэ?	116
Зураг 80. Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоо 2020 оны эхний 9 сартай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн бэ?	117
Зураг 81. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгж хатуу хөл хорионы үед үйл ажиллагаагаа хэрхэн явуулсан бэ?	119
Зураг 82. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгжийн 2021 оны эхний 9 сарын үйл ажиллагаанд Ковид-19 цар тахал яаж нөлөөлсөн бэ?	119
Зураг 83. Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгжийн бизнест хатуу хөл хориотой холбоотой үүссэн хүндрэл бэрхшээл юу вэ?	120
Зураг 84. Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгж ирэх онд бизнесийн үйл ажиллагаандаа ямар үр дүнг хүлээж байна вэ?	122
Зураг 85. Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Цаашид аж ахуйн нэгжийн бизнесийг хөгжүүлэхэд төрийн бодлогын түвшинд нэн тэргүүнд ямар арга хэмжээ авбал зохистой вэ?	123

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЖДҮГ	Жижиг, дунд үйлдвэрийн газар
МУ	Монгол Улс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭЗБӨЧСТ	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

УДИРТГАЛ

Аливаа эдийн засагт шинэ санаа, бүтээлч шийдэл, үнэ цэнийг бий болгогч томоохон хүч нь бизнес эрхлэгчид байдаг. Бизнесийн орчныг судлах, нарийвчлал бүхий өгөгдлийн сан үүсгэх нь эдийн засгийн чадавхыг үнэлэх, ирээдүйн төлөв, боломжийг тодорхойлох, оновчтой бодлого хэрэгжүүлэх суурь юм.

Бизнесийн салбар нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи, ажлын байр зэрэг олон хүчин зүйлээр дамжин улсын хүн амын бүхий л бүлэгт хүрч, нөлөөлж байдаг. Иймээс бизнесийн орчныг сайжруулах, тэгш оролцоог хангах, үр шимийг тэгш хүртээх асуудал чухлаар тавигддаг бөгөөд энэ хүрээнд зайлшгүй анхааран авч үзэх сэдэв бол жендэрийн тэгш байдал юм.

Бизнес эрхлэлтийг жендэрийн ялгаатай байдлаар хэмжихийн тулд нэг талаас бизнес эрхлэлтийг хүйсээр ангилан тодорхойлох, нөгөө талаас бизнес эрхлэлтийн хүйсээр ангилсан өгөгдлийг бүрдүүлэх гэсэн хоёр асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болно.

Монгол Улсын хувьд хууль эрх зүйн хүрээнд бизнес эрхлэлтийг хүйсээр ангилан тодорхойлсон тодорхойлолт одоогоор байхгүй. Хэдийгээр бизнес эрхлэлттэй холбоотой өгөгдөл, статистик мэдээлэл бүрдүүлдэг, тайлагнадаг, үйл ажиллагаандаа ашигладаг байгууллагууд бий боловч тэдгээр нь аргачлал, тодорхойлолтын хувьд ялгаатай тул нэгдсэн байдлаар хүйсээр ангилсан өгөгдлийн сан үүсгэн ашиглахад хүндрэл тулгардаг.

Бизнесийн холбоотой хамгийн өргөн хүрээний өгөгдөл цуглуулж, албан ёсны статистик мэдээлэл бүрдүүлдэг нэг гол эх үүсвэр бол ҮСХ-ны 5 жил тутам зохион байгуулагддаг Аж ахуйн нэгжийн тооллого байдаг. Харин Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллого нь тэдгээр өргөн хүрээний өгөгдлийг хүйсээр буюу аж ахуйн нэгжийн захирлын хүйсээр ангилан анх удаа бизнесийн салбарын хүйсээр ангилсан өгөгдлийн санг бүрдүүлээд байна.

Энэхүү судалгааны хүрээнд Аж ахуйн нэгжийн тооллогын хүйсээр ангилсан өгөгдлийг дэлгэрэнгүй танилцуулж, жендэрийн ялгаатай байдал бий эсэхийг тодруулахыг зорьсон. Мөн тооллогын мэдээллийн сан болон УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн санг нэгтгэх замаар судалгааны хүрээнд аж ахуйн нэгжийн эзэмшигчийн нэг хүйсээр ангилсан өгөгдлийг бүрдүүлж, харьцуулан судалсан. Эзэмшигчийн хүйсээр ангилахдаа нэг хүйсээр буюу 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, мөн 33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг бөгөөд эмэгтэй захиралтай гэсэн шалгуураар тус тус ангилсан өгөгдлийг бүрдүүлэв.

Аж ахуйн нэгжийн хүйсээр ангилсан өгөгдөлд суурилан бизнес эрхлэлт дэх жендэрийн ялгаатай байдлыг дараах 5 бүлгийн хүрээнд тодруулахыг зорьсон. Үүнд:

1. Бизнес эрхлэлт ба жендэр
2. Бизнесийн эдийн засгийн чадавх ба жендэр
3. Бизнес дэх ур чадвар ба жендэр
4. Технологи, инновац, судалгаа хөгжүүлэлт ба жендэр
5. Бизнесийн төлөв, хандлага ба жендэр

Цаашид бизнес эрхлэлтийн хүйсээр ангилсан тодорхойлолт хууль эрх зүйн орчинд бий болсон тохиолдолд түүний дагуу нэгдсэн өгөгдлийн сан үүсгэх боломж бүрдэх юм. Хүйсээр ангилсан өргөн хүрээний өгөгдлийн сан бүрдэх тусам илүү нарийвчилсан жендэрийн дүн шинжилгээ хийх боломж нээгдэнэ.

ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ


АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН ТУХАЙ

Аж ахуйн нэгжийн тооллого нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эрхэлж байгаа ажил, үйлчилгээний чиглэл, байршлыг тогтоож, тэдгээрийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, үүнтэй холбогдон гарах бодлого, шийдвэрт шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой.

ҮСХ нь Аж ахуйн нэгжийн тооллогыг 1991, 1994, 1998, 2006, 2011, 2016, 2021 онуудад нийт 7 удаа зохион байгуулсан. Аж ахуйн нэгжийн 2021 оны ээлжит тооллогыг 2021 оны 11 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 3-ны өдрүүдэд улс даяар зохион байгуулж, тооллогын мэдээллийг цахим асуулгын аргаар цуглуулсан.

СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллого нь Монгол Улсын хэмжээнд өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг хамруулсан. Харин энэхүү судалгааны хүрээнд "Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгж"-ийг хамруулан судалсан. Цаашид энэхүү судалгааны тайланд дурдах аж ахуйн нэгж гэдэг нь Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгж болно.



Зураг 1. Судалгааны хамрах хүрээ


БИЗНЕСИЙН ХҮЙСЭЭР АНГИЛСАН ӨГӨГДӨЛ

Энэхүү судалгааны тайланд Аж ахуйн нэгжийн тооллогын мэдээллийн санг УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сантай уялдуулж, аж ахуйн нэгжийн захирал, эзэмшигч, ажиллагчдын хүйсээрх мэдээлэлд үндэслэн бизнес эрхлэлтийн хүйсээр ангилсан статистикийг туршилтаар гарган авсныг танилцуулж байна.


Эзэмшигчийн хүйсээр ангилахдаа нэг хүйсээр буюу 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, мөн 33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг бөгөөд эмэгтэй захиралтай гэсэн шалгуураар тус тус ангилсан өгөгдлийг бүрдүүлсэн.

Зураг 2. Бизнесийн хүйсээр ангилсан ангилал

Эрэгтэй бизнес эрхлэгч:



Эмэгтэй бизнес эрхлэгч:



БИЗНЕСИЙН САЛБАР ДАХЬ ЖЕНДЭРИЙН ЯЛГААТАЙ БАЙДЛЫГ ХЭМЖИХ НЬ

Бизнес эрхлэлтийн жендэрийн ялгаатай байдлыг нарийвчлан үнэлэхийн тулд бизнесийн байгууллагын захирлын болон ажиллагчдын хүйсээс гадна бизнесийн эзэмшил ба төлөөлөн удирдах түвшин дэх хүйсийн ялгаа, ажиллагчдын албан тушаалын хүйсийн ялгаа, тухайн бизнесийн байгууллага жендэрийн бодлоготой эсэх зэрэг олон үзүүлэлтийг авч үзэх шаардлагатай ч энэхүү тайланд одоогийн боломжит өгөгдөлд үндэслэн бизнесийн байгууллагын захирлын хүйс болон ажиллагчдын хүйсийн ялгааг тодруулан авч үзсэн. Нэмэлтээр эзэмшигчийн нэг хүйсээр ангилсан өгөгдөл буюу эмэгтэй эзэмшигчийн өгөгдлийг харьцуулах зорилгоор бүрдүүлж, судлав.

Тайланд бизнес эрхлэлтийн ерөнхий үзүүлэлтүүд болон бизнесийн эдийн засгийн чадавх, бизнес дэх ур чадвар буюу ажиллагчид, технологи, инновац, судалгаа хөгжүүлэлт, бизнесийн төлөв, хандлагын үзүүлэлтийг бизнесийн захирлын хүйсээр ангилан жендэрийн хувьд ялгаатай байдал хэр байгааг тодруулахыг зорьсон.

ХУРААНГУЙ

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Аж ахуйн нэгжийн тооллогод хамрагдсан 151.6 мянган аж ахуйн нэгжийн 147.4 мянга нь Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгж байна. Үүнээс 37.4 хувь нь буюу 55.1 мянган аж ахуйн нэгж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Харин тооллогын өмнөх 2 жил 44.6 мянган аж ахуйн нэгж тасралтгүй үйл ажиллагаа явуулсан бол 2020 онд 40.3 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулжээ.

2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийг салбараар авч үзвэл дийлэнх буюу 73.2 хувийг үйлчилгээний салбар, тэр дундаа бөөний болон жижиглэнгийн худалдаа зонхилон, 22.1 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 4.6 хувийг хөдөө аж ахуйн салбарын аж ахуйн нэгжүүд бүрдүүлж байна.

Ажиллагчдын тооны бүлгээр 2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн дийлэнх буюу 82.7 хувь нь 1-9 ажиллагчидтай бол ердөө 0.5 хувь нь 200 ба түүнээс дээш ажиллагчидтай том аж ахуйн нэгжүүд байна. Мөн борлуулалтын орлогоор авч үзвэл 71.5 хувь нь жилийн 300 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой бол 6.1 хувь нь 2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд юм. Аж ахуйн нэгжүүдийн 39.8 хувь нь харьцангуй тогтвортой буюу 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулжээ.

БИЗНЕС ЭРХЛЭЛТ БА ЖЕНДЭР

Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогод хамрагдсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан 147.4 мянган аж ахуйн нэгжээс 92.5 мянган аж ахуйн нэгж буюу 62.8 хувь нь эрэгтэй захиралтай, 54.9 мянган аж ахуйн нэгж буюу 37.2 хувь нь эмэгтэй захиралтай бүртгэгджээ. Аж ахуйн нэгжүүдийн захирлын хүйсийн харьцаа 169 буюу 100 эмэгтэй захирал тутамд 169 эрэгтэй захирал ногдож байна.

Цаашилбал, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 60.4 хувь нь эрэгтэй захиралтай, 39.6 хувь нь эмэгтэй захиралтай байна. 2020 онд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн хувьд эрэгтэй болон эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувь тус бүр харгалзан 59.8 хувь ба 40.2 хувь байна.

Аж ахуйн нэгжийн захирлын хүйсээс гадна аж ахуйн нэгжийн эзэмшигчийн хүйсээр өгөгдлийг нарийвчилбал эмэгтэй эзэмшигчтэй буюу 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг аж ахуйн нэгж тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийн 29.6 хувь, 2020 онд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн 32.4 хувийг бүрдүүлж байна. Мөн шалгуурыг нарийвчлан 33.4 ба түүнээс дээш хувийг нь эмэгтэй хүн эзэмшдэг бөгөөд эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувийг тооцвол тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийн 31.2 хувь, 2020 онд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн

нэгжийн 33.1 хувийг бүрдүүлж байна.

Бизнесийн салбарт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд аль аль нь тодорхой хувь нэмэр оруулж буй ч оролцооны хувьд ялгаа ажиглагдаж байна. Захирлын хүйсээр тооцсон эмэгтэй аж ахуй эрхлэгчийн хувь эзэмшигчийн хүйсээр тооцоход буурч буй нь бизнесийн салбарт эмэгтэйчүүдийн оролцоо эрэгтэйчүүдтэй харьцуулахад эрх мэдлийн хувьд бага байгааг, ялангуяа бизнесийн эзэмшлийн түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо сул байгааг илтгэж байна.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр нөхөрлөлөөс бусад бүх хэлбэрүүдэд хүйсийн харьцаагаар эрэгтэйчүүд давамгайлсан хандлага хэвээр байна. Мөн аж ахуйн нэгжийн өмчийн бүх хэлбэрт эрэгтэйчүүд давамгайлж байна. Бизнес эрхлэлтийн хүйсийн ялгаа нь аймаг, нийслэлээр буюу оршин суугаа бүс нутгаар авч үзэхэд мөн зөрүүтэй ажиглагдаж байна.

БИЗНЕСИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХ БА ЖЕНДЭР

Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад цөөн тоогоор бизнес эрхлэхийн дээр эрхэлж буй бизнес нь орлогын хувьд эрэгтэйчүүдийнхээс бага байна. Эрэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж дунджаар 2.0 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлсэн бол эмэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж үүнээс 2 дахин бага буюу 1.0 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлсэн байна.

Орлогын ялгаатай түвшинд аж ахуйн нэгжийн захирлын хүйсээр эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн төлөөллийн ялгааг авч үзвэл орлогын түвшин ихсэх хэрээр эмэгтэйчүүдийн төлөөлөл буурч байна. Тухайлбал, 2.5 тэрбум төгрөг хүртэл орлоготой аж ахуйн нэгжийн хувьд 59.0 хувь нь эрэгтэй, 41.0 хувь нь эмэгтэй захиралтай байхад 2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой том аж ахуйн нэгжийн хувьд хүйсийн ялгаа улам гүнзгийрч эрэгтэй захиралтай аж ахуйн нэгж 71.6 хувийг, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгж 28.4 хувийг бүрдүүлж байна.

2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн 37.0 хувь нь зээлтэй, 63.0 хувь нь зээлгүй байна. Зээлийн эх үүсвэрээр санхүүжилт бүрдүүлэх энэ хандлагыг захирлын хүйсээр авч үзвэл ерөнхийдөө тэнцвэртэй байна. Эрэгтэй болон эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдийн зээлэнд хамрагдалтын түвшин ерөнхийдөө ижил, тулгарч буй асуудал нь ч төстэй боловч Монголбанкны ЖДҮ эрхлэгчдэд олгосон зээлийн хүйсээр ангилсан статистик мэдээллээс харахад зээлийн дүн болон хугацаа хүйсээр ялгаатай байна. Эмэгтэйчүүд илүү урт хугацаатай зээл авдаг ч зээлийн дундаж хэмжээ эрэгтэй зээлдэгчидтэй харьцуулахад бага байна.

БИЗНЕС ДЭХ УР ЧАДВАР БА ЖЕНДЭР

Бизнест захирлын болон эзэмшигчийн хүйсээр эрэгтэйчүүд давамгайлж байсан хандлага бусад ур чадвар буюу ажлын байран дээр ч хадгалагдаж байна.

2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан 40.3 мянган аж ахуйн нэгжид нийт 419.6 мянган ажиллагчид ажиллаж байгаагийн 58.5 хувь нь эрэгтэй ажиллагчид, 41.5 хувь нь эмэгтэй ажиллагчид байна. Харин ажиллагчдын хүйсийн харьцааг авч үзвэл 100 эмэгтэй ажиллагч тутамд ногдох эрэгтэй ажиллагчдын тоо 141 байна.

Эрэгтэй болон эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдийн хувьд ажиллагчдын хүйсийн харьцаа нь мөн ялгаатай байна. Эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувьд эмэгтэй ажиллагчид давамгайлсан байгаа бол эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувьд эрэгтэй ажиллагчид давамгайлсан, хүйсийн харьцаа илүү алдагдсан дүр зураг харагдаж байна.

Ажиллагчдын хүйсийн харьцаа ерөнхийдөө эрэгтэйчүүд давамгайлсан бөгөөд салбараар зарим ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, эрүүл мэнд, боловсролын салбарт бусад салбараас илүү эмэгтэй ажиллагчдын эзлэх хувь өндөр бөгөөд эрүүл мэнд, боловсрол, зочид буудал, зоогийн газар, санхүү, даатгал, бусад үйлчилгээ, бөөний болон жижиглэн худалдаа, урлаг, үзвэр, үл хөдлөх хөрөнгийн салбарын ажиллагчдын талаас илүү хувь нь эмэгтэйчүүд байна.

Бизнесийн хөдөлмөрийн зах зээлд оролцож буй эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын дунд цалин хөлсний ялгаатай байдал ажиглагдаж байна. 2020 онд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдийн дундаж цалин 1.1 сая төгрөг бол эрэгтэй ажиллагчдын дундаж цалин 1.4 сая төгрөг, эмэгтэй ажиллагчдын дундаж цалин 912.0 мянган төгрөг байна. Захирлын хүйсээр авч үзвэл эмэгтэй захиралтай аж ахуйн нэгж эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжтэй харьцуулахад дунджаар 15.4 хувиар өндөр цалин олгож байна.

ТЕХНОЛОГИ, ИННОВАЦ, СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ БА ЖЕНДЭР

2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан 40.3 мянган аж ахуйн нэгжийн 33.0 мянга буюу 81.8 хувь нь үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашиглаж байна. Аж ахуйн нэгжийн захирлын хүйсээр харвал эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 80.9 хувь, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 83.2 хувь нь үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашиглаж байна.

Эмэгтэй захиралтай аж ахуйн нэгж эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжтэй харьцуулахад компьютер, ухаалаг төхөөрөмж, интернет, сүлжээ ашиглах нь ялимгүй илүү байна. Харин дата сервертэй эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн тоо дата сервертэй эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн тооноос олон байна.

2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан 55.8 мянган аж ахуйн нэгж байгаагийн 4.4 мянга нь шинэ эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг нэвтрүүлжээ. Захирлын хүйсийн ялгаагаар

авч үзвэл эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 8.1% хувь буюу 1.8 мянга нь, эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 7.9% буюу 2.7 мянга нь шинэ эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг нэвтрүүлжээ.

Эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд инновацын үйл ажиллагаанд илүү өндөр дүнтэй хөрөнгө оруулалт хийж байна. 2018-2021 онд инновацын үйл ажиллагаа явуулсан эрэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж 2020 онд инновацын үйл ажиллагаандаа дунджаар 48.8 сая төгрөг зарцуулсан бол эмэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж дунджаар 205.1 сая төгрөг зарцуулсан байна.

Судалгаа хөгжүүлэлтийн ажлын хувьд эрэгтэй захиралтай аж ахуйн нэгж эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжтэй харьцуулахад илүү байна. Мөн оюуны өмчийн эрхийн хамгаалалтаар эрэгтэй захиралтай аж ахуйн нэгж эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжтэй харьцуулахад илүү байна. Эрэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагаандаа дунджаар 10.0 сая төгрөг зарцуулсан бол эмэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж дунджаар 7.0 сая төгрөг зарцуулжээ.

БИЗНЕСИЙН ТӨЛӨВ, ХАНДЛАГА БА ЖЕНДЭР

Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан 44.6 мянган аж ахуйн нэгжийн 13.7 хувийнх нь үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ өссөн бол 51.3 хувийнх нь өөрчлөгдөөгүй, 35.0 хувийнх нь буурсан байна. Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ буурсан үзүүлэлт эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувьд 34.9 хувь, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдийн хувьд 35.2 хувь байна. Харин борлуулалтын орлого буурсан нөлөө эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувьд 43.9 хувь, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдийн хувьд 45.0 хувь байна. Эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдийн хувьд ажиллагчдын тоо буурсан хувь 16.3 хувь байгаа нь эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжээс 0.5 хувиар илүү байна.

Ковид-19 цар тахлын үеийн хатуу хөл хорионы үед 2020 онд үйл ажиллагаа явуулсан эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 11.2 хувь нь, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 14.4 хувь нь үйл ажиллагаагаа хэвийн явуулсан байна. Мөн цар тахлын хатуу хөл хорионы үед 2020 онд үйл ажиллагаа явуулсан эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 30.1 хувь нь, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 25.9 хувь нь үйл ажиллагаагаа бүрэн зогсоох шийдвэрт хүрч байжээ. 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг аж ахуйн нэгжийн хувьд энэ үзүүлэлт арай илүү буюу 26.6 хувь, 33.4 ба түүнээс дээш хувийг нь эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувьд 26.7 хувь байна. Эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувьд цар тахлын нөлөө сөргөөр нөлөөлсөн хувь эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжтэй харьцуулахад өндөр байна.

Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдийн 2022 оны бизнесийн хүлээлтийг тодруулахад 45.0 хувь нь эерэг хүлээлттэй, 10.2 хувь нь сөрөг хүлээлттэй байна. Захирлын хүйсээр хүлээлтийг тодруулахад эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 44.7 хувь нь эерэг хүлээлттэй бол эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 45.5 хувь нь эерэг хүлээлттэй байна.



1

БИЗНЕС ЭРХЛЭЛТ

ба

ЖЕНДЭРИЙН
ТУХАЙ ОЙЛГОЛТ

- 1.1 Жендэр ба жендэрийн бодлогын тухай
- 1.2 Жендэрийн мэдрэмжтэй бизнес эрхлэлтийн бодлого
- 1.3 Бизнес эрхлэлтийн жендэрийн статистик

1.1

ЖЕНДЭР БА ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ТУХАЙ

Хүйс нь хүний биеийн биологийн ялгаагаар тодорхойлогддог бол жендэр нь илүү өргөн хүрээтэй буюу янз бүрийн хүйсийн хүмүүсийн нийгэмд бий болсон шинж чанар, үнэлэмж, үүрэг, байр суурийг илэрхийлдэг. Жендэрийн тухай ойлголт нь нийгэм, эдийн засаг, соёлын нөхцөл байдлаас хамаарч өөр өөр бөгөөд хувьсан өөрчлөгдөж болдог харьцангуй ойлголт юм.

4.1.1."жендэр" гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг;

Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)

Нийгэмд оршин буй хүнд "оноосон" ялгаатай шинж чанар, үүрэг, үнэлэмж, боломж ба бэрхшээлийг дан ганц хүйсээр тодорхойлох боломжгүй. Тиймээс ч дэлхий дахинд "нийгмийн хүйс" гэгдэх жендэрийн асуудлыг анхааран авч үзэж, жендэрийн эрх тэгш байдлыг тогтвортой хөгжлийн нэг зорилгоор тодорхойлж, түүнийг хангахаар зорин ажиллаж байна. Жендэрийн эрх тэгш байдал нь янз бүрийн хүйсийн хүмүүс нийгмийн амьдралд тэгш эрхтэйгээр оролцож, тэгш боломжоор хангагдаж, хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх тухай юм.

4.1.2."жендэрийн эрх тэгш байдал" гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг;

Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт "улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй ..." хэмээн аливаа харилцаанд хүйсээс үл хамааран тэгш эрхтэй болохыг баталгаажуулсан. Жендэрийн эрх тэгш байдлыг илүү нарийвчлан зохицуулах зорилгоор Монгол Улс 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг баталж, хууль эрхзүйн орчин бүрдээд даруй 10 гаруй жил өнгөрчээ. Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахад хийх шаардлагатай ажлууд бий бөгөөд хуульд заасан хүйсийн хувьд тэгш оролцоог хангах хэд хэдэн хэмжигдэхүйц квотууд хараахан биелээгүй байна.

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг “Жендэрийн ялгаатай байдлын индекс”¹ судалгааны 2022 оны тайланд Монгол Улс 0.715 оноогоор (0-1 хүртэл оноогоор үнэлсэн, 0 – тэгш бус байдал, 1- тэгш байдал) 146 улсаас 70 дугаарт эрэмбэлэгдсэн. Манай улс боловсрол (0.994 оноо), эрүүл мэндийн (0.980 оноо) үзүүлэлтээр харьцангуй тэгш байдалтай гэж үнэлэгдсэн бол эдийн засгийн оролцоо (0.765 оноо) болон улс төрийн эрх мэдэл (0.121 оноо) үзүүлэлтээр тэгш бус байдал илэрсэн байна. Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин өндөр хэдий ч шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоогоор хангалтгүй, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин доогуур, цалин хөлсний хувьд тэгш бус байдал буйг судалгаанаас харах боломжтой байна.

Түүнчлэн ҮСХ-ноос тооцдог Жендэрийн тэгш бус байдлын индексийн² үнэлгээ 2021 оны байдлаар 0.367 байгаа бөгөөд Монгол Улсын “Алсын хараа 2050”-д тус индексийг 0 хүртэл бууруулах бодлого тусгагдаад буй. Жендэрийн тэгш байдлыг хангахын тулд жендэрийн мэдрэмжтэй бодлого шаардлагатай. Жендэрийн мэдрэмжтэй бодлого гэдэг нь аль нэг хүйсэд зориулсан тусдаа бодлого бус харин аль аль хүйсийн онцлогийг харгалзан үзэж, тэдний хэрэгцээнд нийцсэн, ялгаатай хүйсийн тэгш эрхийг хангахад чиглэсэн бодлого боловсруулахыг хэлнэ.

Жендэрийн мэдрэмжтэй бодлого нь нийгэм дэх тэгш бус байдлыг бууруулах, тэгш боломжийг нээх, цаашлаад хүн бүрийн амьдралын чанарыг сайжруулахад нөлөөлөх ач холбогдолтой юм.

¹ Global Gender Gap Report 2022, World Economic Forum

² Хүйсийн тэгш бус байдлаас шалтгаалах хүний хөгжлийн гурван хэмжүүр болох нөхөн үржихүйн эрүүл мэнд, боловсролын байдал болон шийдвэр гаргах эрх мэдэл, хөдөлмөрийн зах зээл дэх оролцоогоор хэмжигдэх нийлмэл индекс, 0 – тэгш байдал, 1 – тэгш бус байдал, ҮСХ

1.2

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГО

Бизнесийн салбар бол улс орны хөгжлийн тулгуур. Хүн амын хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшин, эдийн засгийн чадавх, технологийн хөгжил цаашлаад улсын хөгжлийн түвшин бизнесийн салбарын цар хүрээтэй салшгүй уялдаатай. Монгол Улсын хувьд зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш бизнесийн салбар хөгжиж, эдийн засагт оруулах хувийн хэвшлийн хувь нэмэр улам бүр нэмэгдэж, 2021 оны байдлаар ДНБ-ий 76.2 хувийг хувийн хэвшил бүрдүүлж³ байна.

Монгол Улс нь Дэлхийн банкны орлогын ангиллаар бага-дунд орлоготой орны тоонд багтдаг, цөөн хүн амтай, эдийн засгийн төрөлжилт сул, хувийн хэвшлийн дийлэнх нь ЖДҮ эрхлэгчдээс бүрддэг хөгжиж буй орон бөгөөд бизнесийн таатай орчин бүрдүүлэх, бизнес эрхлэгчдээ дэмжих замаар эдийн засгаа чадавхжуулах, хүн амын амьдралын чанарыг сайжруулахаар анхаарч буй юм.

Бизнесийн салбар нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи, ажлын байр зэрэг олон хүчин зүйлээр дамжин улсын хүн амын бүхий л бүлэгт хүрч, нөлөөлж байдаг. Иймээс бизнесийн орчныг сайжруулах, тэгш оролцоог хангах, үр шимийг тэгш хүртээх асуудал чухлаар тавигддаг бөгөөд энэ хүрээнд зайлшгүй анхааран авч үзэх нэг тал нь жендэрийн тэгш байдал юм.

Том зургаар харвал Монгол Улс жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар анхааран авч үзэж, хууль, бодлого, хөтөлбөрүүдэд харьцангуй сайн тусгаж өгсөн байна. Гэсэн хэдий ч бизнесийн салбарыг тусгайлан авч үзвэл жендэрийн ялгааг нарийвчлан үнэлсэн үнэлгээ дутмаг, жендэрийн мэдрэмжтэй, чиглэсэн бодлого үгүй байна. Жишээ нь: Бизнесийн салбарт олон нийтэд хувьцаа нь нээлттэй арилжаалагддаг, хөрөнгийн биржэд бүртгэлтэй компаниудын ТУЗ-д жендерийн квот тогтоодог бодлогыг Монгол Улсад хэрэгжүүлж болох юм. Дэлхийн томоохон хөрөнгийн биржүүд, тухайлбал NASDAQ, бүртгэлтэй компаниуддаа 2022 оноос хойш эхлэн жендерийн тэгш байдлыг хангах шаардлага тавьж эхэлсэн. Олон нийтэд нээлттэй компаниуд ийм жишиг тогтоосноор хувийн болон хаалттай компаниуд энэ жишгийг дагах хандлага үүсэх үр нөлөөтэй.

Аливаа салбар, түвшинд жендэрийн мэдрэмжтэй байх гэдэг нь хүйсийн ялгаатай байдлыг анхаарч авч үздэг, хүйсээс үл хамаарсан тэгш оролцоо, тэгш боломжийг дэмждэг, энэхүү боломжийг хязгаарлаж буй жендэрийн хэвшмэл ойлголтуудыг өөрчлөхийг зорьдог хандлага юм. Харин жендэрийн мэдрэмжтэй бодлого гэдэг нь жендэрийн үзэл баримтлалыг тусгах замаар бодлогыг жендэрийн агуулгатай болгохыг хэлнэ.

³ ДНБ-д хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь, УСХ, 2021 он

1.3

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ЖЕНДЭРИЙН СТАТИСТИК

Жендэрийн мэдрэмжтэй оновчтой бодлого хэрэгжүүлэхийн тулд зайлшгүй бодит өгөгдөл буюу хүйсээр ангилсан өгөгдөл, жендэрийн дүн шинжилгээ, судалгаанд суурилах шаардлагатай. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд хүйсээр ангилсан албан ёсны статистик мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангах тухай зарчмыг тусгасан ч бизнесийн салбарт бодлогын шийдвэр гаргалтад ашиглахуйц өргөн хүрээний, нарийвчлал сайтай нэгдсэн өгөгдлийн сан бүрдэж амжаагүй байна.

Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Татварын ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан зэрэг төрийн байгууллагууд болон арилжааны банкууд өөр өөрийн үйл ажиллагааны хүрээнд хүйсээр ангилсан бизнесийн өгөгдлийг бүрдүүлж ирсэн ч эдгээр нь аргачлал, тодорхойлолтын хувьд ялгаатай байдаг тул нэгдсэн байдлаар хүйсээр ангилсан өгөгдлийн сан болгон ашиглахад хүндрэл тулгардаг. Үүний хамгийн том нэг шалтгаан нь эрэгтэй, эмэгтэй бизнес эрхлэгчийн нэгдсэн тодорхойлолт байхгүй, байгууллага бүр өөр өөрийн тодорхойлолтыг ашиглаж ирсэн явдал юм. Нэгдсэн ойлголт, тодорхойлолтгүйн улмаас бодит өгөгдөлд суурилан нөхцөл байдлыг зөв үнэлж, чиглэсэн бодлого тодорхойлоход хүндрэл тулгарах, бодлогын хэрэгжилт гажих, зорилтот бүлэгтээ хүрч чадахгүй байх, цаашлаад бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд хүндрэл учирч байна. Иймээс бизнес эрхлэлтийн хүйсээр ангилсан үнэн зөв мэдээлэл бүрдүүлэхийн тулд улс орны хэмжээнд нэг мөр ашиглаж болохуйц, яв цав тодорхойлолт шаардлагатай.

Сүүлийн үед хөдөлмөрийн зах зээл болон бизнесийн орчинд эмэгтэйчүүдийн оролцоо аль ч салбарт дутмаг буйтай холбоотойгоор эмэгтэй бизнес эрхлэгчийн тодорхойлолтыг бий болгох, эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжих хууль эрх зүйн орчин бий болгох замаар бизнесийн салбарт хүйсийн тэгш оролцоог хангах тухай хэлэлцүүлгүүд өрнөж байна. Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, эдийн засгийн хувьд чадавхжуулах нь дан ганц эмэгтэйчүүдийг дэмжсэн асуудал биш, бизнесийн орчинд тэгш оролцоог бий болгож, бизнесийн салбарыг бүхэлд нь эрчимжүүлээд зогсохгүй цаашлаад өрх, гэр бүлийн орлого өсөх, хүүхдийн боловсрол, эрүүл мэнд сайжрах гэх мэт нийгмийн асуудлуудыг цогцоор шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Дэлхийн олон улсад эмэгтэй бизнес эрхлэгчийг дэмжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, эмэгтэй бизнес эрхлэгчийн тодорхойлолтыг бий болгосон туршлага бий. Тухайлбал, АНУ-д Эмэгтэйчүүдийн бизнес өмчлөх тухай хуулийг 1988 онд, БНСУ-д Жижиг, дунд үйлдвэрлэл, гарааны бизнесийн яамыг 1996 онд байгуулж, Эмэгтэйчүүдийн эрхэлдэг бизнест дэмжлэг үзүүлэх тухай хуулийг 1999 онд, Филиппин Улсад Бичил болон

жигжиг дунд бизнес эрхэлдэг эмэгтэйчүүдийг дэмжих тухай хуулийг 1995 онд тус тус баталж, хэрэгжүүлж байна. Монгол Улсад бизнесийн салбар, жигжиг, дунд үйлдвэр, татварын холбоотой хууль тогтоомжуудад жендэрийн чиглэсэн бодлого байхгүй байна.

Эмэгтэй бизнес эрхлэгчийн тодорхойлолтын хувьд олон улсын байгууллагууд болон улс орон бүр өөр өөрийн ялгаатай тодорхойлолтыг боловсруулсан байдаг ба зарим жишээг дурдвал:

- Европын сэргээн босголт, хөгжлийн банк: Компанийн үйл ажиллагааны ерөнхий удирдлагыг эмэгтэй хүн хэрэгжүүлдэг, эсвэл бизнесийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн эмэгтэй хүн өмчилдөг буюу эзэмшдэг бизнесийг эмэгтэй удирдлагатай бизнес гэнэ.
- Олон улсын санхүүгийн корпораци: Эмэгтэйчүүдийн өмчилдөг буюу эзэмшдэг бизнес гэж эмэгтэй хүн 51 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг, эсвэл 20 буюу түүнээс дээш хувийг эмэгтэй хүн буюу эмэгтэйчүүд өмчилдөг, 1 буюу түүнээс дээш тооны эмэгтэйчүүд Гүйцэтгэх захирал/Үйл ажиллагаа хариуцсан захирал (Ерөнхийлөгч/Дэд ерөнхийлөгч)-аар ажилладаг ба Захирлуудын зөвлөлийн 30 буюу түүнээс дээш хувь нь эмэгтэйчүүд байх тохиолдлыг хэлнэ.
- Азийн хөгжлийн банк: Бизнесийн 50-иас доошгүй хувийг эмэгтэйчүүд өмчилдөг буюу эзэмшдэг, эсвэл дээд удирдлагын 60-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд, эсвэл нийт бүртгэлтэй ажиллагчдын 50-иас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байвал эмэгтэйчүүд өмчилдөг буюу эзэмшдэг бизнес гэж тооцно.
- АНУ-ын Жигжиг бизнесийн захиргаа: Эмэгтэйчүүд эзэмшдэг бизнес гэж бизнесийн дор хаяж 51 хувийг шууд буюу ямарваа нөхцөлгүйгээр нэг ба түүнээс дээш тооны эмэгтэйчүүд өмчилдөг бөгөөд нэг буюу түүнээс дээш тооны эмэгтэй хүн хянадаг тохиолдлыг хэлнэ.
- Энэтхэг: Эмэгтэй бизнес эрхлэгчид аж ахуйг өмчилдөг бөгөөд хөрөнгийн 51-ээс дээш хувийг эзэмших замаар хяналт тавьдаг, аж ахуйн нэгжийн бий болгосон ажлын байрны наад зах нь 51 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг бол эмэгтэй бизнес гэнэ.
- Их Британийн Эдийн засаг, санхүүгийн яам: Бизнесийн дор хаяж 51 хувийг нэг буюу түүнээс дээш эмэгтэй хүн өмчилдөг бөгөөд Гүйцэтгэх захирал/Үйл ажиллагаа хариуцсан захирлын жагсаалтад эмэгтэй хүн байдаг бол эмэгтэй удирдлагатай бизнес гэнэ.

Эдгээр тодорхойлолтоос анзаарвал ерөнхийдөө бизнесийн эзэмшигчдийн хүйс, удирдлагын хүйс, эсвэл ажиллагчдын хүйсийн үзүүлэлтэд үндэслэн эмэгтэй бизнес эрхлэгчийг тодорхойлж байна. Монгол Улсын хувьд ч мөн адил өөрийн улсын онцлогт тохируулан эмэгтэй болон эрэгтэй бизнес эрхлэгчийн тодорхойлолтыг боловсруулж, холбогдох хууль тогтоомжид тусгаж өгснөөр бодлогын түвшинд мөрдлөг болгох нэг ойлголттой болох, бизнесийн салбарын жендэрийн

өгөгдөл бүрдэх, бизнесийн салбар дахь хүйсийн ялгааг нарийвчлан үнэлэх, хөдөлмөрийн зах зээл болон бизнесийн салбар дахь жендэрийн тэгш оролцоог бий болгох, жендэрийн мэдрэмжтэй чиглэсэн бодлого хэрэгжүүлэх үндэс болох юм.

Судалгааны хүрээнд танилцуулж буй Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогын мэдээлэл нь бизнесийн салбарын хамгийн том өгөгдлийн санг бүрдүүлснээс гадна хүйсээр ангилсан өгөгдлийг бий болгосноороо онцлогтой. Аж ахуйн нэгжийн тооллого нь ҮСХ-ноос 5 жил тутам зохион байгуулагддаг бөгөөд 2021 оны тооллогоор анх удаа хүйсээр буюу аж ахуйн нэгжийн захирлын хүйсээр ангилсан өргөн хүрээний өгөгдлийн санг бүрдүүлээд буй юм.

Мөн тооллогын мэдээллийн сан болон УБЕГ-ын Хуулийн этгээдийн мэдээллийн санг нэгтгэх замаар энэхүү судалгааны хүрээнд аж ахуйн нэгжийн мэдээллийг эзэмшигчийн нэг хүйсээр ангилсан өгөгдлийг бүрдүүлж, харьцуулан судалсан. Эзэмшигчийн хүйсээр ангилахдаа нэг хүйсээр буюу 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, мөн 33.4 ба түүнээс дээш хувийг нь эмэгтэй хүн эзэмшдэг бөгөөд эмэгтэй захиралтай гэсэн шалгуураар тус тус ангилсан өгөгдлийг бүрдүүлэв.

Аж ахуйн нэгжийн мэдээллийг зөвхөн захирлын хүйсээр ангилах нь бизнесийн жендэрийн нөхцөл байдлын бүрэн дүр зургийг харуулж чадахгүй бөгөөд бизнесийн гол шийдвэр гаргалт эзэмшигчтэй холбоотой байдаг тул энэ төрлийн мэдээлэл зайлшгүй шаардлагатай. Гэсэн хэдий ч одоогоор эрэгтэй болон эмэгтэй бизнес эрхлэгчийн тодорхойлолт байхгүй, түүнчлэн бизнесийн эзэмшигчтэй холбоотой нарийвчилсан нээлттэй өгөгдлийн сан бүрдээгүй тул судалгааны хүрээ, цаг хугацаа, боломжид тулгуурлан харьцуулах зорилгоор нэг хүйсийн мэдээллийг бүрдүүлсэн. Энэ нь жендэрийн статистикийн хувьд учир дутагдалтай хэдий ч захирлын хүйсээр ангилсан мэдээлэлд нэмэлт мэдээлэл болохуйц ач холбогдолтой гэж үзлээ. Тэр дундаа эмэгтэй эзэмшигчийн мэдээллийг сонгон бүрдүүлсэн нь ямар нэг тусгай зорилго агуулаагүй бөгөөд олон улсад эмэгтэй бизнес эрхлэгчийг тодорхойлсон тодорхойлолтууд түгээмэл байдаг нь шууд ашиглахад дөхөм байсантай холбоотой юм.

Цаашид бизнес эрхлэгчийн хүйсээр ялгаатай тодорхойлолт бий болсон тохиолдолд түүнд уялдуулан энэхүү өгөгдлийн санг илүү өргөжүүлэх, бусад байгууллагуудын өгөгдлийн сантай нэгтгэх замаар бизнесийн салбарын хүйсээр ангилсан өгөгдлийн санг үүсгэж, бизнес эрхлэгчдийн онцлог, ялгаатай байдлыг тусгасан жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулахад ашиглах боломжтой.



2

БИЗНЕС ЭРХЛЭЛТ ба

ЖЕНДЭР

- 2.1 Бизнес эрхлэлтийн үндсэн үзүүлэлт
- 2.2 Бизнес эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн жендэрийн ялгаатай байдлыг хэмжих нь

2.1

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Бизнес эрхлэлтийн цар хүрээг тоон утгаар авч үзвэл аж ахуйн нэгжийн тоо сүүлийн 5 удаагийн тооллогын явцад тасралтгүй өсөж, 2021 оны тооллогод 151.6 мянган аж ахуйн нэгж хамрагдсан байна. 5 жилийн өмнөх буюу 2016 оны тооллоготой харьцуулахад аж ахуйн нэгжийн тоо 49.9 хувиар нэмэгджээ. Сүүлийн 3 удаагийн тооллогын хувьд аж ахуйн нэгжийн тооны өсөлтийн дундаж хувь 79.6 хувь буюу тооллого тус бүрийн хооронд бизнес эрхлэлтийн идэвх ийм хэмжээний өсөлттэй байв.

Тооллогод хамрагдсан 151.6 мянган аж ахуйн нэгжийн 147.4 мянга нь Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгж байна. Бизнес эрхлэлтийн хамгийн түгээмэл хэлбэр нь ХХК буюу Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн 92.7 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэртэй байна. Харин нээлттэй хувьцаат компани цөөн буюу нийт аж ахуйн нэгжийн 0.2 хувийг бүрдүүлж байна.

Зураг 3. Тооллогод хамрагдсан нийт ААН-ийн тоо, тооллого явагдсан оноор







14 040


1998

26 841

2006

Зураг 4. МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, хариуцлагын хэлбэрээр, 2021 он

		Тоо	%
	ХХК	136 692	92.7
	Нөхөрлөл	4 713	3.2
	Хоршоо	4 097	2.8
	ТӨҮГ/ОНӨҮГ	428	0.3
	ХК	294	0.2
	Бусад	1 175	0.8
Бүгд		147 399	100.0




Сүүлийн 3 жил гаруйн хугацаанд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр бизнесийн орчин хумигдаж, бизнесийн үйл ажиллагаа доголдох нөхцөл байдал үүссэн. Тооллогын хүрээнд аж ахуйн нэгжийг үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар нь үйл ажиллагаа явуулж байгаа болон үйл ажиллагаа явуулаагүй (үйл ажиллагаа эхлээгүй, түр зогсоосон, бүрэн зогсоосон, бусад) гэж бүртгэдэг. 2021 оны аж ахуйн нэгжийн тооллогод хамрагдсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан 147.4 мянган аж ахуйн нэгжийн 92.3 мянга нь үйл ажиллагаа явуулаагүй бол 55.1 мянга нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Цаашилбал, үйл ажиллагаа явуулж буй 55.1 мянган аж ахуйн нэгжээс 44.6 мянган аж ахуйн нэгж тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан бол 40.3 мянган аж ахуйн нэгж 2020 онд үйл ажиллагаа явуулжээ.

Үйл ажиллагаа явуулаагүй 92.3 мянган аж ахуйн нэгжийн 48.1 хувь нь үйл ажиллагаагаа түр зогсоосон, 19.8 хувь нь үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон төлөвтэй бол 31.4 хувь нь үйл ажиллагаа огт эхлээгүй аж ахуйн нэгжүүд байна. Үйл ажиллагаагаа түр зогсоосон төлөвтэй 44.4 мянган аж ахуйн нэгжийн өгөгдлийг цаашид нарийвчлан судлах замаар тэдгээр бизнес эрхлэгчдийг идэвхжүүлэх, дэмжих шийдэл гаргах шаардлагатай. Мөн бүртгүүлсэн боловч үйл ажиллагаа огт эхлээгүй 29.0 мянган аж ахуйн нэгжийн хувьд шалтгааныг нь тодруулж, үйл ажиллагаагаа идэвхижүүлэх тодорхой хугацаа өгч үгүй бол бүртгэлээс хасах гэх мэт арга хэмжээ авах нь зүйтэй.


Зураг 5. МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, 2021 он




Аж ахуйн нэгжийн төвлөрөл нь эдийн засаг, бизнесийн орчин, хүн амын нягтрал, шилжих хөдөлгөөн зэрэг олон хүчин зүйлээс хамааран газар зүйн бүс нутгаар ялгаатай буюу ерөнхийдөө хот, суурин газар төвлөрөл илүү өндөр байдаг. Монгол Улсын иргэнээр удирдуулсан тооллогод хамрагдсан 147.4 мянган аж ахуйн нэгжийн 73.8 хувь, Монгол Улсын иргэнээр удирдуулсан 2020 онд үйл ажиллагаа явуулсан 40.3 мянган аж ахуйн нэгжийн 65.6 хувь нь Улаанбаатар хотод төвлөрч байна.

Төвийн бүсэд хүн амын нягтрал болоод эдийн засгийн чадавхаар харьцангуй өндөр Дархан-Уул аймаг, газар тариалангийн бүс нутаг болох Сэлэнгэ аймаг, уул уурхайн үйл ажиллагаа идэвхтэй Өмнөговь аймгуудад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд харьцангуй их төвлөрчээ. Орхон аймаг бусад аймгуудтай харьцуулахад Улаанбаатар хотын дараа орох хамгийн олон тооны идэвхтэй бизнес эрхлэгчтэй бөгөөд Хангайн бүсэд төвлөрч байна. Харин Баруун бүсэд Увс, Ховд аймгууд бизнес эрхлэгчийн тоогоор өндөр байна.

Зураг 7. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, бүсээр



Зураг 6. Үйл ажиллагаа явуулаагүй МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, шалтгаанаар, 2021 он



Зураг 8. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, өмчийн хэлбэрээр


	Тоо	%
Монгол Улсын иргэний өмч	39 401	97.8
Төрийн болон орон нутгийн өмч	396	1.0
Гадаад улсын иргэний өмч	296	0.7
Гадаад улсын иргэнтэй хамтарсан	213	0.5
	40 306	100.0

Аж ахуйн нэгжүүдийг өмчийн хэлбэрээр авч үзвэл 2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн дийлэнх буюу 97.8 хувь нь Монгол Улсын иргэний хувийн өмчийнх байна.

Бизнес эрхлэлтийн салбарын бүтцийг нарийвчилж харвал 2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн дийлэнх буюу 73.2 хувийг үйлчилгээний салбар, тэр дундаа бөөний болон жижиглэнгийн худалдаа зонхилон, 22.1 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 4.6 хувийг хөдөө аж ахуйн салбарын аж ахуйн нэгжүүд бүрдүүлж байна.

Үйлчилгээний салбарт бөөний болон жижиглэн худалдааны бизнесүүд илүү олон тоогоор үйл ажиллагаа явуулж байгаа бол аж үйлдвэр, барилгын салбарт хүнсний бүтээгдэхүүн, ундаа, тавилга, хувцас үйлдвэрлэл гэх мэт боловсруулах үйлдвэрлэл хийгээд барилгын салбарын бизнесүүд түлхүү ажиллаж байна.


Зураг 9. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагааны чиглэлээр



2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан 40.3 мянган аж ахуйн нэгжийн 39.8 хувь нь харьцангуй тогтвортой буюу 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан бол 30.3 хувь нь 6-10 жил үйл ажиллагаа явуулсан, 25.6 хувь нь 2-5 жил үйл ажиллагаа явуулжээ. Харин 4.3 хувь нь буюу 1.7 мянган аж ахуйн нэгж 1 жил хүртэл хугацаанд үйл ажиллагаа явуулсан шинэ бизнесүүд юм.

5 жил хүртэл хугацаанд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж 29.9 хувийг, харин 5-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж 70.1 хувийг бүрдүүлж байгаа нь аж ахуйн нэгжийн дийлэнх нь тогтвортой үйл ажиллагаа явуулж ирснийг харуулж байна. Нөгөөтэйгүүр 1 жил хүртэл хугацаанд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж ердөө 4.3 хувийг бүрдүүлж буй нь цар тахлын нөлөөгөөр шинээр бизнес эхлүүлэх боломж бага байсныг илтгэж болох юм.

Зураг 10. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаа явуулж буй хугацаагаар




Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль (2019)-д заасны дагуу “жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж 200 хүртэл ажиллагчидтай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг тодорхойлсон.

ЖДҮ эрхлэгчийг хуульд заасан ажиллагчдын тоо болон борлуулалтын орлогын дүн аль алианаар нь зэрэг тодорхойлоход хүндрэлтэй бөгөөд ЖДҮ эрхлэгчээр бүртгүүлсэн аж ахуйн нэгжийн статистик мэдээлэл гардаг ч зөвхөн аливаа төсөл, хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлд хамрагдахын тулд бүртгүүлсэн байдаг тул мөн л бүрэн гүйцэд дүр зургийг харахад хүндрэлтэй байдаг.

Хуульд заасан тодорхойлолтын дагуу зөвхөн ажиллагчдын тооны бүлгээр авч үзвэл 2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн 99.5 хувь нь 200 хүртэл ажиллагчидтай, ЖДҮ ангилалд багтах аж ахуйн нэгжүүд бол ердөө 0.5 хувь нь 200 ба түүнээс дээш ажиллагчидтай том аж ахуйн нэгжүүд байна. Цааш нарийвчилбал, аж ахуйн нэгжийн дийлэнх буюу 82.7 хувь нь 1-9 ажиллагчидтай бичил аж ахуйн нэгж ангилалд багтахар байна. Энэ нь зөвхөн тооллогын өгөгдөлд суурилсан дүн бөгөөд ЖДҮ эрхлэгчээр бүртгүүлсэн албан ёсны статистик биш юм.

Зураг 11. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, ажиллагчдын тооны бүлгээр




Мөн аж ахуйн нэгжүүдийг хуульд заасан борлуулалтын орлогын ангиллаар авч үзвэл дийлэнх буюу 93.9 хувь нь 2.5 тэрбум төгрөг хүртэл жилийн борлуулалтын орлоготой ЖДҮ ангилалд багтах бол 6.1 хувь нь 2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой том аж ахуйн нэгжүүд ангилалд багтахар байна.

Борлуулалтын орлогын ангиллыг дахин нарийвчлан авч үзвэл 71.5 хувь нь жилийн 300 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой бичил аж ахуйн нэгжүүд ангилалд багтахуйц байна.

Аж ахуйн нэгжүүдийг хэмжээгээр нь ангилж, түүний дагуу чиглэсэн бодлого хэрэгжүүлэх нь чухал бөгөөд ийм төрлийн бодлого тодорхойлохын тулд мөн л бодитой өгөгдөл бүрдүүлэх шаардлагатай. Хуульд заасан ЖДҮ-ийн тодорхойлолтыг илүү ойлгомжтой томъёолох, ажиллагчдын тоо, борлуулалтын орлогоор ангилахдаа аль үзүүлэлтийг нь чухалчлан авч үзэхийг нарийвчлан заах, тодорхойлолтын дагуу статистик мэдээллийг хэрхэн бүрдүүлэх тухай тусгах, ЖДҮ эрхлэгчээр бүртгэх үйл явцыг хялбарчлах замаар нэгдсэн бүртгэлийн санг бий болгож бодитой өгөгдөл бүрдүүлэх нь зүйтэй.

Зураг 12. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, борлуулалтын орлогын бүлгээр



2.2

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ЖЕНДЭРИЙН ЯЛГААТАЙ БАЙДЛЫГ ХЭМЖИХ НЬ

Бизнес эрхлэлтийн үзүүлэлтүүд буюу аж ахуйн нэгжийн мэдээллийг хүйсээр ангилан судлах нь аж ахуй эрхлэгчийн хүйсээр ангилсан тодорхойлолт байхгүй, хүйсээр ангилсан өгөгдлийн сан бүрдээгүй гэсэн хоёр үндсэн шалтгааны улмаас хүндрэлтэй асуудал юм.

Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогын хүрээнд аж ахуйн нэгжийн мэдээллийг захирлын хүйсээр ангилан бүрдүүлсэн нь анх удаа энэ төрлийн хүйсээр ангилсан хамгийн өргөн хүрээний мэдээллийн санг бий болгосон. Гэсэн хэдий ч аж ахуй эрхлэлтийн үзүүлэлтийг дан ганц захирлын хүйсээр ангилан жендэрийн ялгаатай байдлыг хэмжих боломжгүй бөгөөд олон улсад ашиглагдаж буй тодорхойлолтуудын дагуу авч үзвэл аж ахуйн нэгжийн эзэмшигчийн хүйсийг голлон, дээрээс нь ажиллагчдын хүйсийг давхар хамруулан жендэрийн ялгааг хэмжих нь түгээмэл байна. Иймээс судалгааны хүрээнд аж ахуйн нэгжийн мэдээллийг тооллогын мэдээлэлд үндэслэн захирлын хүйсээр ангилан судалснаас гадна нэмэлтээр судалгааны боломжид тулгуурлан эзэмшигчийн нэг хүйсээр ангилсан өгөгдөл буюу эмэгтэй эзэмшигчийн өгөгдлийг харьцуулах зорилгоор бүрдүүлж судлав.

Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогод хамрагдсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан 147.4 мянган аж ахуйн нэгжээс 92.5 мянган аж ахуйн нэгж буюу 62.8 хувь нь эрэгтэй захиралтай, 54.9 мянган аж ахуйн нэгж буюу 37.2 хувь нь эмэгтэй захиралтай бүртгэгджээ. Аж ахуйн нэгжүүдийн захирлын хүйсийн харьцаа 169 буюу 100 эмэгтэй захирал тутамд 169 эрэгтэй захирал ногдож байна.


Цаашилбал, үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн 60.4 хувь нь эрэгтэй захиралтай, 39.6 хувь нь эмэгтэй захиралтай байна. 2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн хувьд эрэгтэй болон эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувь тус бүр харгалзан 59.8 хувь ба 40.2 хувь байна.

Бизнесийн салбарт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд аль аль нь тодорхой хувь нэмэр оруулж буй ч оролцооны хувьд ялгаа ажиглагдаж байна. Аж ахуйн нэгжийн захирлын хүйсээс гадна аж ахуйн нэгжийн эзэмшигчийн хүйсээр өгөгдлийг нарийвчилбал эмэгтэй эзэмшигчтэй буюу 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг аж ахуйн нэгж тооллогод хамрагдсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн 29.6 хувь, 2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн 32.4 хувийг бүрдүүлж байна. Мөн шалгуурыг нарийвчлан 33.4 ба түүнээс дээш хувийг нь эмэгтэй хүн эзэмшдэг бөгөөд эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувийг тооцвол тооллогод хамрагдсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн 31.2 хувь, 2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн 33.1 хувийг эзэлж байна.


Захирлын хүйсээр тооцсон эмэгтэй аж ахуй эрхлэгчийн хувь эмэгтэй эзэмшигчийн хүйсээр тооцоход буурч буй нь бизнесийн салбарт эмэгтэйчүүдийн оролцоо эрэгтэйчүүдтэй харьцуулахад эрх мэдлийн хувьд бага байгааг, ялангуяа бизнесийн эзэмшлийн түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо сул байгааг илтгэж байна. Гэхдээ үүгээр бизнесийн салбарын жендэрийн ялгаатай байдлыг шууд дүгнэх боломжгүй бөгөөд боломжит өгөгдөл буюу тооллогын үр дүнд бүрдсэн мэдээллүүд дээр үндэслэн энэхүү судалгаагаар нарийвчлан судлахыг оролдох болно.

Зураг 13. МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, дүнд эзлэх хувиар, 2021 он


Тооллогод хамрагдсан








Үйл ажиллагаа явуулж байгаа



Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан



2020 онд үйл ажиллагаа явуулсан




Эрэгтэй захиралтай
Эмэгтэй захиралтай


51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг

33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай

Зураг 14. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, хариуцлагын хэлбэрээр, захирлын хүйсээр, дүнд эзлэх хувиар




Зураг 15. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, өмчийн хэлбэрээр, захирлын хүйсээр, дүнд эзлэх хувиар




Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр нөхөрлөлөөс бусад бүх хэлбэрүүдэд хүйсийн харьцаагаар эрэгтэйчүүд давамгайлсан хандлага хэвээр байна. Хувьцаат компанийн хувьд захирлын хүйсийн харьцаа хамгийн өндөр буюу 341 байна. Бизнес эрхлэлтийн хамгийн түгээмэл хэлбэр болох ХХК-ийн хувьд хүйсийн харьцаа 151 байгаа бол нөхөрлөл хэлбэрийн аж ахуйн нэгжийн хувьд хүйсийн харьцаа 88 буюу эмэгтэй захирал давамгайлсан байна. Эмэгтэй эзэмшигчтэй бизнесийн хувь эмэгтэй захиралтай бизнесийн эзлэх хувиас бага, тэр дундаа нөхөрлөл, хоршооны хувьд зөрүү өндөр байна.

Зураг 16. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, хариуцлагын хэлбэрээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар



Зураг 17. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, өмчийн хэлбэрээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар



Мөн аж ахуйн нэгжийн өмчийн бүх хэлбэрт эрэгтэйчүүд давамгайлж байна. Үүнд төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн захирлын хүйсийн харьцаа хамгийн өндөр буюу 313 байхад Монгол Улсын иргэний өмчийн аж ахуйн нэгжийн хувьд 148 байна. Гадаад улсын иргэний өмчит аж ахуйн нэгжүүдийн хувьд захирлын хүйсийн харьцаа харьцангуй тэнцвэртэй буюу 107 байна.

Эмэгтэй эзэмшигчтэй бизнесийн хувь эмэгтэй захиралтай бизнесийн хувиас мөн бага байгаа бөгөөд гадаад улсын иргэний өмчит аж ахуйн нэгжийн хувьд энэ ялгаа хамгийн өндөр байна. Өөрөөр хэлбэл бизнест өмчлөлийн эрх мэдэл нэмэгдэх тусам эрэгтэйчүүдийн оролцоо давамгайлах хандлагатай байна.


Бизнес эрхлэлтийн хүйсийн ялгаа нь аймаг, нийслэлээр буюу оршин суугаа бүс нутгаар авч үзэхэд мөн зөрүүтэй байдал ажиглагдаж байна. Бүсүүд дотроо Зүүн бүсэд бизнес эрхлэлтийн хүйсийн ялгаа эрэгтэй 53.4 хувь, эмэгтэй 46.6 хувь буюу харьцангуй тэнцвэртэй байгаа бол бусад аймгууд болон Улаанбаатар хотод бизнесийн салбарт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илт бага оролцоотой байна.

Баян-Өлгий, Ховд, Архангай, Увс аймгуудад бизнес эрхлэлтийн хүйсийн ялгаа хамгийн өндөр буюу эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн тоотой харьцуулахад эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн тоо 1.8-аас 3.3 дахин бага байна.


Бизнес эрхлэлтийн хүйсийн ялгаа өндөр Баян-Өлгий, Ховд, Увс аймаг орших Баруун бүсийн хувьд бүсийн дүнгээр хүйсийн ялгаа хамгийн өндөр буй юм. Мөн бусад бүс, аймгуудын хувьд аж ахуйн нэгжийн тоогоор хэмжигдэх бизнесийн идэвхжил нь нэмэгдэх тусам эмэгтэй захиралтай байх магадлал буурах хандлага ажиглагдаж байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн 60.6 хувь нь эрэгтэй захиралтай, 39.4 хувь нь эмэгтэй захиралтай байгаа бол 21 аймгийн дундаж дүнгээр 58.2 хувь нь эрэгтэй захиралтай, 41.8 хувь нь эмэгтэй захиралтай байна. Улаанбаатар хот болон бүсүүдээр эмэгтэй эзэмшигчтэй бизнесийн хувь эмэгтэй захиралтай бизнесийн хувиас 7-8 хувиар бага байна.

Зураг 18. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, бүсээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар



Зураг 19. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, аймаг, нийслэлээр, захирлын хүйсээр, дүнд эзлэх хувиар



Бизнесийн салбарт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг тэнцүү тоотой оролцуулна гэж ярихаас илүү хүн амын хүйсийн харьцаа бараг тэнцүү байхад яагаад аль нэг хүйс давамгайл байгаа цаад шалтгаан, асуудлыг тодруулж, тэгш боломж хангагдаж чадаж буй эсэхийг нарийвчлан судлах шаардлагатай.

Монгол Улсын 3.3 сая хүн амын⁴ 49.3 хувь нь эрэгтэй, 50.7 хувь нь эмэгтэй буюу хүйсийн харьцаа ерөнхийдөө тэнцвэртэй байна. Харин нийт 1.2 сая ажиллах хүчний 52.9 хувь нь эрэгтэйчүүд, 47.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Цаашилбал хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувийг ажиллах хүчин эзэлж байгааг харуулдаг ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэйчүүдийнх 65.2 хувь байхад эмэгтэйчүүдийнх 49.9 хувь, хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувийг ажиллагчид эзэлж байгааг харуулдаг хөдөлмөр эрхлэлтийн түвшин эрэгтэйчүүдийнх 59.6 хувь байхад эмэгтэйчүүдийнх 46.0 хувь байна.⁵

Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт нарийсах тусам эмэгтэйчүүдийн оролцоо буурч буй нь юутай холбоотой вэ? Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 14 жилийн өмнө буюу 2008 онд 62.8 хувь байсан бол 2021 онд 49.9 хувь болж даруй 12.9 хувиар буурчээ. Үүний нэг том шалтгаан нь эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн үүрэгтэй холбоотой. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо буурсантай давхцаад 2008 оноос төрөлтийн ерөнхий коэффициент нэмэгдэж, 2000-2007 онд жилд дунджаар 19.4 байсан бол 2008-2021 онд 25.0 болж өссөн⁶. Ялангуяа төрөлтийн түвшин өндөр байдаг 20-34 насны хүн амын дунд ажиллах хүчний оролцооны хүйсийн ялгаа хамгийн их байгаа юм.

Эмэгтэйчүүд хүүхэд тээж, төрүүлэх нь богино хугацааны үйл явц биш, доод тал нь 1-2 жил хөдөлмөр эрхлэхээ зогсоох шаардлагатай болдог. Ялангуяа хүүхэд асрах үйлчилгээ, хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүртээмж сул өнөөгийн нөхцөлд бүр ч удаан хугацаагаар эмэгтэйчүүд гэртээ хүүхдээ асрах шаардлагатай болж байна. Нөгөөтэйгүүр хүүхэд асрах нь эмэгтэй хүний үүрэг гэх нийгмийн хэвшмэл ойлголт хүчтэй хэвээр. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийг хөдөлмөрийн зах зээлд түлхүү оролцуулахын тулд төрөлтийг дэмжихийн хажуугаар хүүхэд асрахтай холбоотой үйлчилгээг сайжруулах, эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн үүргээ биелүүлэхийн сацуу нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжийг нэмэгдүүлэх бодлого шаардлагатай.

2021 оны Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар гэрээсээ цахимаар ажиллах боломжийн талаар зохицуулалт орсон нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нэг хэлбэр гэж үзэж буй бөгөөд цаашлаад

⁴ Монгол Улсад оршин суугаа хүн амын тоо, ҮСХ, 2021 он

⁵ Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, ҮСХ, 2021 он

⁶ Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох амьд төрсөн хүүхдийн тоо, ҮСХ

эмэгтэйчүүд хүүхдээ асрангаа ажил хийх боломжийг нэмэгдүүлэх илүү нарийвчилсан бодлогыг бий болгох шаардлагатай. Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо сүүлийн жилүүдэд тогтвортой буурахад нөлөөлж буй шалтгаанууд байсаар байхад бизнесийн салбарт ч тэдний оролцоо нэмэгдэх боломжгүй юм.

ҮСХ-ны 2019 оны Цаг ашиглалтын судалгааны үр дүнгээс харвал Монгол эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1-8 дахин их хугацааг гэрийн ажил, хүүхэд асрах гэх мэт хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байна. Эрэгтэйчүүд өдөрт дунджаар 2 цагийг хүүхэд, гэр бүлийн гишүүдийг асрах, гэрийн ажил хийхэд зарцуулдаг бол эмэгтэйчүүд өдөрт дунджаар 4.7 цагийг зарцуулж байна. Энэ ялгаа нь насны бүлэг, гэрлэсэн эсэх, хүүхэдтэй эсэх, хөдөлмөр эрхэлдэг эсэх, хотод эсвэл хөдөө амьдарч буйгаас хамааран улам нэмэгдэж эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдтэй харьцуулахад 1-8 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байна.

Хүүхэд асрах, гэрийн ажил хийх, гэр бүлийн өндөр настан, өвчтэй гишүүдийг асрах зэрэг ажил нь ихэнхдээ эмэгтэйчүүдэд оногддог. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа зогссон хугацаанд эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөр эрхлэх цаг улам бүр нэмэгдсэн. Эдгээр шалтгааны улмаас эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдтэй адил цагийг хөдөлмөр эрхлэх, бизнес эрхлэхэд зарцуулах боломж хязгаарлагдмал байна. Эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрийг үнэлдэг болгох, нийгмийн хэвшмэл ойлголтыг арилгах, хүүхэд асрах зэрэг хөлсгүй хөдөлмөртэй холбоотой үйлчилгээг сайжруулах нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, цаашлаад бизнес эрхлэлтийг дэмжихэд чухал нөлөөтэй.


Эмэгтэйчүүд боловсролын түвшингээр эрэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр, боловсролд илүү цаг зарцуулдаг ч хөдөлмөрийн зах зээлд гарах үед эрэгтэйчүүдтэй адил цагийг хөдөлмөр эрхлэхэд зарцуулах боломж нь хязгаарлагдаж байна. Тооллогод хамрагдсан үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн хувьд эрэгтэй захирлуудын 68.8 хувь нь дээд боловсролтой байхад эмэгтэй захирлуудын хувьд энэ үзүүлэлт 74.9 хувь байна⁷. Хөдөлмөр эрхлэлтийн жендэрийн ялгаатай байдал нь бизнес эрхлэлтийн хувьд ч хадгалагдаж буй юм. Үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн захирлын хүйсийн ялгааг харвал эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд харгалзан 60.4 хувь ба 39.6 хувийг эзэлж байна.

⁷ Хүн ам, өрхийн мэдээллийн сан, ҮСХ

Эмэгтэйчүүд бизнес эрхлэх шийдвэр гаргах, улмаар бизнесийг удирдан авч явах боломж бүрдэхэд олон хүчин зүйлс нөлөөлж буйн нэгэн адил бизнесийн салбаруудын онцлог нь эмэгтэйчүүд бизнес эрхлэхэд нөлөөлдөг буюу эмэгтэйчүүдэд нээлттэй эсвэл тохиромжтой салбарууд байж болох юм. Учир нь эмэгтэйчүүд давамгайлдаг бизнес эрэгтэйчүүдийнхээс өөр салбарт байршиж байна. Тухайлбал, эрүүл мэнд, боловсрол, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээний салбарт эмэгтэй захиралтай бизнес харьцангуй олон бол уул уурхай, барилга, тээвэр, мэдээлэл, холбоо болон хөдөө аж ахуйн салбарт эрэгтэйчүүд илт давамгайлж байна.

2020 онд үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулсан нийт аж ахуйн нэгжийн 55.3 хувь, хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн 69.8 хувь, аж үйлдвэр, барилгын салбарт үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн 72.5 хувь нь эрэгтэй захиралтай байна. Эзэмшигчийн хувьд авч үзвэл эмэгтэй эзэмшигчтэй аж ахуйн нэгжийн хувь мөн л эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжээс бага байна.

Зураг 20. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, салбараар, захирлын хүйсээр, дүнд эзлэх хувиар



Аж үйлдвэр, барилгын салбарт аж ахуйн нэгжийн захирлын хүйсээр авч үзэхэд хүйсийн зөрүүтэй байдал илүү өндөр бол үйлчилгээний салбарт харьцангуй тэнцвэртэй ч эрэгтэй захирал давамгайлсан хэвээр байна. Салбаруудыг нарийвчлан авч үзвэл эрүүл мэнд, боловсрол, зочид буудал, зоогийн газар, санхүү, даатгал, жижиглэн худалдааны салбарт эмэгтэй захиралтай бизнес арай давамгай буюу 50 ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байна. Эмэгтэйчүүдийн бизнес эрхэлж буй салбар харьцангуй хязгаарлагдмал, уул уурхай, барилга гэх мэт эдийн засгийн тэргүүлэх салбаруудад эмэгтэйчүүдийн оролцоо бага байгаа нь эдийн засгийн хувьд жендэрийн асуудлыг үүсгэх өндөр магадлалтай.

Эдийн засгийн бүх салбарт эмэгтэй эзэмшигчтэй аж ахуйн нэгжийн хувь эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжээс бага байгаа нь эмэгтэйчүүд бизнесийн удирдах түвшинд ажилласан ч бизнесийг эзэмших тал дээр эрэгтэйчүүд давамгайлдаг болохыг харуулж байна. Энэ зөрүү санхүү, даатгал, боловсрол, эрүүл мэндийн салбарт хамгийн их байна. Эдгээр салбарт эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн эзлэх хувьд 50 ба түүнээс дээш байсан хэдий ч бизнесийн эзэмшигчийн хувьд эмэгтэйчүүдийн оролцоо эргээд буурч байгаа нь анхаарал татаж байна. Түүнчлэн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн бизнес эрхэлж буй салбарын ялгаатай байдал нь мэргэжил сонголтын жендэрийн асуудлыг эргэн харах шаардлагатайг сануулж байж болох. Зарим салбарт бизнес эрхлэгчдийн хүйсийн ялгаа хэт өндөр байгаа нь анхаарах асуудал юм.

Зураг 21. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, салбараар, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар

ХӨДӨӨ
АЖ АХУЙ



АЖ ҮЙЛДВЭР,
БАРИЛГА



ҮЙЛЧИЛГЭЭ




51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг



33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай

Зураг 22. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, салбараар, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар




Бизнесийн цар хүрээг ажиллагчдын тооны бүлгээр ангилж харвал аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоо нэмэгдэх тусам эрэгтэй захиралтай байх хандлагатай байна. Эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 19.1 хувь нь 10-аас дээш тооны ажиллагчидтай байхад эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 14.8 хувь нь 10-аас дээш тооны ажиллагчидтай байна. 200-аас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжийн хувьд захирлын хүйсийн ялгаа улам нэмэгдэж 71.1 хувь нь эрэгтэй захиралтай, 28.9 хувь нь эмэгтэй захиралтай байна.

Ажиллагчдын тооны бүлгээр эмэгтэй эзэнтэй бизнес эрхлэгчийн хувь эмэгтэй захиралтай бизнес эрхлэгчдийн эзлэх хувиас мөн бага, ялангуяа ажиллагчдын тоо нэмэгдэх тусам энэ хандлага нэмэгдэж байна. 200 ба түүнээс дээш тооны ажиллагчидтай аж ахуйн нэгжийн 28.9 хувь нь эмэгтэй захиралтай байсан бол 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг тохиолдолд энэ хувь 11.9 хувь, 33.4 ба түүнээс дээш хувийг нь эмэгтэй хүн эзэмшдэг бөгөөд эмэгтэй захиралтай тохиолдолд 11.0 хувь болж буурч байна.

Эрэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж дунджаар 12 ажиллагчидтай бол эмэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж дунджаар 8 ажиллагчидтай үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 23. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, ажиллагчдын тооны бүлгээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар




Эрэгтэй захиралтай Эмэгтэй захиралтай

Борлуулалтын орлогын ангиллаар мөн л эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд илүү чадавхтай байна. Эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 31.0 хувь нь жилийн 300 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой байхад эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 24.8 хувь нь жилийн 300 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой байна. Бизнесийн борлуулалтын орлого нэмэгдэх тусам эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн эзлэх хувьтай харьцуулахад эмэгтэй эзэмшигчтэй аж ахуйн нэгжийн эзлэх хувь буурах хандлага хэвээр ажиглагдаж байна.

Жилийн 2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой 2.4 мянган аж ахуйн нэгж 2020 онд үйл ажиллагаа явуулснаас 1.8 мянга нь эрэгтэй захиралтай, 696 нь эмэгтэй захиралтай аж ахуйн нэгж байна. Эрэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгжийн дундаж борлуулалтын орлого 2.0 тэрбум төгрөг бол эмэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого дунджаар 1.0 тэрбум төгрөг байна.

Зураг 24. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, борлуулалтын орлогын бүлгээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар




Зураг 25. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаа явуулж буй хугацаагаар, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар

Борлуулалтын орлогын бүлгээр эрэгтэй болон эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл ялгаатай буюу аль ч бүлэгт эрэгтэйчүүд давамгайлсан нь бизнесийн орчинд давамгайлж буй хүйсийн хандлагыг дагасан үр дүнг харуулж байна.

Эрэгтэй болон эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд тус бүрийн дотор үйл ажиллагаа явуулсан хугацаагаар нь бүтцийг харвал тогтвортой үйл ажиллагаа явуулсан хугацаагаар эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд ялимгүй илүү байна. Эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдийн 39.0 хувь нь 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан бол эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдийн 41.0 хувь нь 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулжээ. 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг аж ахуйн нэгжүүдийн 40.0 хувь, 33.4 ба түүнээс дээш хувийг нь эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдийн 40.1 хувь нь 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулж байна.


Эрэгтэй эзэмшигчтэй аж ахуйн нэгж илүү өндөр борлуулалтын орлоготой, илүү олон ажиллагчидтай бөгөөд урт хугацаанд үйл ажиллагаа явуулах магадлалтай гэж хэлж болохоор байна.

Эрэгтэй захиралтай ●
Эмэгтэй захиралтай ●





ЗУРАГ 26. БИЗНЕС ЭРХЛЭГЧИД ГЭЖ ХЭН БЭ?

Монгол Улсын иргэнээр удирдуулсан үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн захирлын албан тушаалыг хашиж буй 55.1 мянган бизнес эрхлэгч нь:



Эх үүсвэр: Хүн ам, өрхийн мэдээллийн сан, УСХ





3

БИЗНЕСИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХ ба

ЖЕНДЭР

- 3.1 Бизнесийн орлого бүрдүүлэлт ба жендэрийн ялгаатай байдал
- 3.2 Бизнесийн санхүүжилт, хөрөнгө оруулалт ба жендэрийн ялгаатай байдал

3.1

БИЗНЕСИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТ БА ЖЕНДЭРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ


Бизнесийн үр дүнгийн цар хүрээг борлуулалтын орлогын түвшнээр хэмжихэд 2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан эрэгтэй захиралтай 24.1 мянган аж ахуйн нэгж нийт 48.9 их наяд төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлсэн бол эмэгтэй захиралтай 16.2 мянган аж ахуйн нэгж нийт 16.0 их наяд төгрөгийн борлуулалтын орлогыг бүрдүүлжээ. Харин аж ахуйн нэгжийн эзэмшигчийн тухайд аж ахуйн нэгжийн 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг бизнесийн нийт борлуулалтын орлого 10.1 их наяд төгрөг, 33.4 ба түүнээс дээш хувийг нь эмэгтэй хүн эзэмшдэг бөгөөд эмэгтэй захиралтай бизнесийнх 8.2 их наяд төгрөг байна.

Эрэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж дунджаар 2.0 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлсэн бол эмэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж үүнээс 2 дахин бага буюу 1.0 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлсэн байна.


Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад цөөн тоогоор бизнес эрхлэхийн дээр эрхэлж буй бизнес нь орлогын хувьд эрэгтэйчүүдийнхээс бага буй нь бизнесийн салбарт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд тэгш оролцох, хөгжлийн үр шимээс тэгш хүртэхэд ямар нэг гажуудал байгааг илтгэж байна.

Зураг 27. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн нийт борлуулалтын орлого, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр

Нийт борлуулалтын орлого, их наяд төгрөг




Нэг ААН-д ногдох дундаж борлуулалтын орлого, тэрбум төгрөг



- Эрэгтэй захиралтай
- Эмэгтэй захиралтай
- 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг
- 33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай

Орлогын ялгаатай түвшинд аж ахуйн нэгжийн захирлын хүйсээр эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн төлөөллийн ялгааг авч үзвэл орлогын түвшин ихсэх хэрээр эмэгтэйчүүдийн төлөөлөл буурч байна. Тухайлбал, 2.5 тэрбум төгрөг хүртэл орлоготой аж ахуйн нэгжийн хувьд 59.0 хувь нь эрэгтэй, 41.0 хувь нь эмэгтэй захиралтай байхад 2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой том аж ахуйн нэгжийн хувьд хүйсийн ялгаа улам гүнзгийрч эрэгтэй захиралтай аж ахуйн нэгж 71.6 хувийг, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгж 28.4 хувийг бүрдүүлж байна. Цаашилбал эмэгтэй эзэмшигчтэй аж ахуйн нэгжийн хувьд авч үзвэл 2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой том аж ахуйн нэгжийн 18.7 хувь нь 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг аж ахуйн нэгж байхад 16.5 хувь нь 33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгж байна.

Зураг 28. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, борлуулалтын орлогын бүлгээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар



Аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого нэмэгдэх тусам бизнесийн захирлын хүйсийн ялгаа нэмэгдэж, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн тоо буурах хандлага юутай холбоотой вэ?


Монголбанк 2021 оноос банкны салбарын зарим гол үзүүлэлтүүдийг хүйсээр ангилан зарлах болсон. Тухайлбал, иргэдийн харилцах, хадгаламж, зээл, ЖДҮ эрхлэгчдэд олгосон зээлийн үзүүлэлтийг хүйсээр ангилан харах боломж бүрдсэн. 2022 оны эцсийн байдлаар банкуудад давхардсан тоогоор 5.9 сая иргэдийн харилцах данс, 3.2 сая хадгаламжийн данс бүртгэлтэй байгаагаас харилцах дансны 47.1 хувь нь эрэгтэй харилцагчийнх бол 52.9 хувь нь эмэгтэй харилцагчийнх, хадгаламжийн дансны 43.3 хувь нь эрэгтэй харилцагчийнх бол 56.7 хувь нь эмэгтэй харилцагчийнх байна. Харилцах дансны хувьд нэг дансны дундаж үлдэгдэл эрэгтэй харилцагчийн хувьд эмэгтэйчүүдийнхээс 18.6 хувиар өндөр, хадгаламжийн хувьд эрэгтэйчүүдийн хадгаламжийн нэг дансны дундаж үлдэгдэл эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад 10.1 хувиар өндөр байна.

Нийт иргэдийн зээлийн дансны 39.5 хувийг эрэгтэйчүүд, 60.5 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Харин нэг эрэгтэй харилцагч дунджаар 10.3 сая төгрөгийн зээл авч байхад нэг эмэгтэй харилцагч үүнээс 47.4 хувиар бага буюу 5.4 сая төгрөгийн зээл авчээ. Эмэгтэйчүүд харилцах болон хадгаламжийн дансны хэрэглээ өндөр, эрэгтэйчүүдээс илүү хуримтлал үүсгэдэг, зээл авах тоогоор илүү хэдий ч нэг харилцагчид ногдох дүнгээр авч үзвэл эдгээр үзүүлэлтүүд эрэгтэйчүүдээс бага байна.

Цаашилбал, Монголбанкны ЖДҮ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжид олгосон зээлийн хүйсээр ангилсан мэдээгээр 2022 оны эцсийн байдлаар 5.4 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэл байгаагаас 63.7 хувь нь эрэгтэй зээлдэгчийнх, 36.3 хувь нь эмэгтэй зээлдэгчийнх байна. Нэг зээлдэгчид ногдох зээлийн дундаж хэмжээ эрэгтэй зээлдэгчийн хувьд 89.9 сая төгрөг бол эмэгтэй зээлдэгчийн хувьд 45.2 хувиар бага буюу 49.3 сая төгрөг байна. Харин зээлийн дундаж хугацааг авч үзвэл эрэгтэйчүүд дунджаар 31.0 сар, эмэгтэйчүүд дунджаар 34.3 сарын хугацаатай зээл авчээ. Мөн зээлийн жилийн дундаж хүү эрэгтэй зээлдэгчдийн хувьд 13.1 хувь, эмэгтэй зээлдэгчдийн хувьд 13.0 хувь байна. Чанаргүй зээлийн хувь эрэгтэйчүүдийн хувьд 13.2 хувь, эмэгтэйчүүдийн хувьд 9.6 хувь байна. Эмэгтэй ЖДҮ эрхлэгчдийн зээлийн чанаргүйдэл бага, эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү урт хугацаатай, бага хүүтэй зээл авч байгаа ч авч буй зээлийн хэмжээ эрэгтэйчүүдийнхээс бага байгаа нь анхаарал татаж байна. Эмэгтэйчүүд илүү урт хугацаатай, бага хүүтэй зээл авч байгаа нь эмэгтэй зээлдэгчдэд тусгайлан зориулсан хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээ банкны салбарт нэвтэрсэнтэй холбоотой байж болох юм. Мөн зээлийн шаардлага, барьцаа хөрөнгө зэргээс үүдээд эмэгтэйчүүд их дүнтэй зээл авах боломж хязгаарлагдмал байж болох. 2018 онд Азийн хөгжлийн банк, ҮСХ хамтран “Хөрөнгийн эзэмшил, аж ахуй эрхлэлтийг жендэрийн төлөв байдлаар тодорхойлох нь” туршилтын судалгааг зохион байгуулсан. Судалгааны үр дүнгээр гэр бүлийн үл хөдлөх хөрөнгийг эрэгтэй гишүүн өмчлөх/ эзэмших хандлагатай буюу сууц эзэмшлээр эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2 дахин, ХАА-н газрын хувьд 3-6 дахин, бусад үл хөдлөх хөрөнгийн хувьд 1.5 дахин их байна. Судалгаанд хамрагдсан иргэдээс эрэгтэйчүүдийн 60 хувь, эмэгтэйчүүдийн 33 хувь нь сууцаа өөрөө өмчилдөг/ эзэмшдэг гэж мэдээлсэн байна. Эмэгтэйчүүдийн эрхэлж буй бизнес нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад жижиг байдаг нь санхүүжилтийн эх үүсвэр олоход хүндрэл учирдагтай холбоотойг үгүйсгэхгүй.


Зураг 29. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, борлуулалтын орлогын бүлгээр, салбараар, эрэгтэй захирлаар, дүнд эзлэх хувиар

Аж ахуйн нэгжүүдийг борлуулалтын орлогын бүлгээр авч үзвэл орлого нэмэгдэх тусам буюу аж ахуйн нэгж томрох тусам эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн тоо буурах хандлага бүр илүү тод харагдаж байна.




Зөвхөн зочид буудал, зоогийн газрын салбарт энэ хандлага эсрэгээрээ байгаа юм. Эрүүл мэнд, боловсролын салбарт эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд дийлэнх байдаг ч 2.5 тэрбум төгрөгөөс дээш жилийн борлуулалтын орлоготой том аж ахуйн нэгжийн хувьд эргээд эмэгтэйчүүдийн оролцоо буурч байна.

Зураг 30. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, борлуулалтын орлогын бүлгээр, салбараар, эмэгтэй захирал, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар



Зураг 31. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаа явуулж буй хугацаагаар, борлуулалтын орлогын бүлгээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар



● Эрэгтэй захиралтай
● Эмэгтэй захиралтай


■ 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг

■ 33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай

Борлуулалтын орлого ба үйл ажиллагаа явуулсан хугацаагаар бизнесийн жендэрийн ялгааг авч үзвэл аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого болон үйл ажиллагаа явуулсан хугацаа нэмэгдэх тусам эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувь буурч байна.


Борлуулалтын орлого бага боловч урт хугацаанд үйл ажиллагаа явуулсан эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувь харьцангуй өндөр байхад бизнесийн орлого нэмэгдэх хэрээр эрэгтэй захиралтай байх магадлал нэмэгдэж байна. Эмэгтэй эзэмшигчийн тухайд бизнесийн цар хүрээ өргөжих тусам тэдний оролцоо эмэгтэй захирлын оролцоотой харьцуулахад илүү ихээр буурч байна.

Зураг 32. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг байрны эзэмшлээр, захирлын хүйсээр, дүнд эзлэх хувиар



Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг байрны эзэмшлийн тухайд эрэгтэй захиралтай нийт аж ахуйн нэгжийн 45.9 хувь нь үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй байраа эзэмшдэг буюу аж ахуйн нэгжийн болон үүсгэн байгуулагчийн эзэмшлийн байртай байна. Харин энэ үзүүлэлт эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувьд 47.6 хувь байна. Эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд орлогын хувьд эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдээс бага байсан ч үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг байраа эзэмших байдал нь харьцангуй өндөр байна.

Зураг 33. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, борлуулалтын орлогын бүлгээр, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг байрны эзэмшлээр, захирлын хүйсээр, дүнд эзлэх хувиар



Эрэгтэй захиралтай ● Эмэгтэй захиралтай ●

ЭКСПОРТ БА ОЛОН УЛСЫН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ

2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан 40.3 мянган аж ахуйн нэгжээс 3.8 хувь буюу 1.5 мянган аж ахуйн нэгж экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаж байна. Үүнээс 552 нь тогтмол экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг бол 965 нь заримдаа буюу тогтмол бус экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаж байна.

Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжийн 63.6 хувь нь эрэгтэй захиралтай аж ахуйн нэгж бол 36.4 хувь нь эмэгтэй захиралтай аж ахуйн нэгж, 27.0 хувь нь 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, 26.7 хувь нь 33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгж байна. Экспортод тогтмол бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжийн 61.1 хувь нь эрэгтэй захиралтай, 38.9 хувь нь эмэгтэй захиралтай аж ахуйн нэгж байна.


2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжээс 97 аж ахуйн нэгж олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд хамрагдсан ба үүний 48.5 хувь нь эрэгтэй захиралтай, 51.5 хувь нь эмэгтэй захиралтай аж ахуйн нэгж байна.

Сонирхолтой нь экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжийн 57.9 хувь нь 300 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой жижиг аж ахуйн нэгж байна. Мөн ажиллагчдын тооны хувьд экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг нийт аж ахуйн нэгжийн 64.3 хувь нь 1-9 ажиллагчидтай аж ахуйн нэгжүүд байна.

2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд экспортод бүтээгдэхүүн гаргадаг аж ахуйн нэгжийн 17.3 хувийг бүрдүүлж байна. 200 ба түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжийн ердөө 3.2 хувийг бүрдүүлж байна.

Том аж ахуйн нэгжүүдээс илүү жижиг аж ахуйн нэгжүүд экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргах хандлага их байгаа нь аж ахуйн нэгжийн захирлын хүйсээр авч үзэхэд ерөнхийдөө ижил байна.

Зураг 34. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг эсэхээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр



3.2


БИЗНЕСИЙН САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА ЖЕНДЭРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн 37.0 хувь нь зээлтэй, 63.0 хувь нь зээлгүй байна.

Зээлийн эх үүсвэрээр санхүүжилт бүрдүүлэх энэ хандлагыг захирлын хүйсээр авч үзвэл ерөнхийдөө тэнцвэртэй буюу зээлтэй, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувь зээлтэй, эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжээс 0.9 хувиар бага байна.

Эмэгтэй эзэмшигчтэй аж ахуйн нэгжийн хувьд зээлтэй аж ахуйн нэгжийн хувь 37.1-37.9 хувь байна.

Зураг 35. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, зээл авсан эсэхээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар




Эрэгтэй захиралтай

Эмэгтэй захиралтай

51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг

33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай

Зураг 36. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан зээлтэй ААН-ийн тоо, ажиллагчдын тооны бүлэг, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар




Зээлийн эх үүсвэрээр санхүүжилт бүрдүүлэх нь аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоо нэмэгдэх тусам өндөр байна. Нийт дүнгээрээ эмэгтэй захиралтай болон эзэмшигчтэй аж ахуйн нэгжийн зээлэнд хамрагдалт ижил байгаа ч 200 ба түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжийн хувьд зээлэнд хамрагдсан байдал нь эмэгтэй эзэмшигчтэй аж ахуйн нэгжүүдэд өндөр байна. 200 ба түүнээс дээш ажиллагчидтай эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 66.7 хувь нь зээлэнд хамрагдсан бол 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг аж ахуйн нэгжийн 73.1 хувь, 33.4 ба түүнээс дээш хувийг нь эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 70.8 хувь нь зээлэнд хамрагджээ.

Зураг 37. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан зээлтэй ААН-ийн тоо, борлуулалтын орлогын бүлгээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар

Аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоо нэмэгдэх тусам зээлийн эх үүсвэрээр санхүүжилт бүрдүүлэх нь өндөр байсантай ижил аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого нэмэгдэх тусам зээлэнд хамрагдалт өндөр байна. Мөн ажиллагчдын тоо нэмэгдэх тусам эмэгтэй эзэмшигчтэй аж ахуйн нэгж зээлэнд хамрагдсан хувь өндөр байна.


Эрэгтэй, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдийн хувьд зээлэнд хамрагдалт ерөнхийдөө ижил байгаа ч Монголбанкны ЖДҮ эрхлэгчдийн зээлийн мэдээллээс харахад эмэгтэйчүүдийн авч буй зээлийн хэмжээ эрэгтэйчүүдийнхээс бага байгаа нь анхаарах шаардлагатай үзүүлэлт юм.



- Эрэгтэй захиралтай
- Эмэгтэй захиралтай
- 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг
- 33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай

Зээлийн эх үүсвэрээр харвал зээлэнд хамрагдсан нийт аж ахуйн нэгжийн дийлэнх нь буюу 77.6 хувь нь банкнаас зээл авч байна. Түүний дараа 16.3 хувь нь хувь хүнээс зээл авч буй нь ББСБ, ХЗХ зэрэг мэргэжлийн байгууллагуудаас зээл авснаас илүү өндөр хувьтай байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь магадгүй зээлийн шаардлага, нөхцөлөөс хамаардаг байж болох юм.

Зураг 38. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан зээлтэй ААН-ийн тоо, зээлийн эх үүсвэрээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, давхардсан тоогоор, дүнд эзлэх хувиар




Эмэгтэйчүүдийн хувьд банкнаас зээл авах хандлага эрэгтэйчүүдийнхээс илүү, хувь хүнээс зээл авах нь эрэгтэйчүүдийнхээс бага байна. Эмэгтэйчүүд илүү эрсдэл багатай, найдвартай байгууллагаас зээл авах сонирхолтой байж болох юм.

Сүүлийн жилүүдэд дотоодын банк, санхүүгийн байгууллагууд эмэгтэйчүүдэд зориулсан санхүүгийн бүтээгдэхүүн санал болгож эхэлсэн бөгөөд эмэгтэй бизнес эрхлэгчийн нэгдсэн тодорхойлолт байхгүй тул байгууллага бүр янз бүрээр тодорхойлж, ялгаатай шалгуур тавьж байна.

2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн 63.0 хувь нь буюу 25.4 мянган аж ахуйн нэгж ямар нэг зээлэнд хамрагдаагүй байна. Зээлэнд хамрагдаагүй аж ахуйн нэгжүүдийг зээлэнд хамрагдаагүй шалтгаанаар авч үзвэл давхардсан хувиар 47.4 хувь нь зээлэнд хамрагдах шаардлагагүй бол 36.8 хувь нь барьцаа хөрөнгө болон зээлийн бусад шалгуурыг хангаагүй улмаас зээлэнд хамрагдаж чадаагүй байна. Эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 35.1 хувь нь зээлийн шалгуурыг хангаагүйн улмаас зээлэнд хамрагдаж чадаагүй бол эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 37.9 хувь нь ийм шалтгаанаар зээл авч чадаагүй байна.

Зураг 39. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, зээлэнд хамрагдаагүй шалтгаанаар, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, давхардсан тоогоор, дүнд эзлэх хувиар




Эмэгтэй эзэмшигчтэй аж ахуйн нэгжүүдийн хувьд энэ хувь ерөнхийдөө ижил байна. Бизнесийн салбарыг дэмжихэд санхүүжилтийн асуудал хамгийн чухал бөгөөд эрэгтэй болон эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдийн зээлэнд хамрагдалтын түвшин ерөнхийдөө ижил, тулгарч буй асуудал нь төстэй боловч зээлийн дүн болон хугацааны хувьд ялгаатай байгааг анхаарч бизнесийн санхүүжилтийн асуудлыг шийдэхдээ эрэгтэй болон эмэгтэй бизнес эрхлэгчийн онцлогт тохируулсан ялгаатай бодлого, ялгаатай санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх нь илүү үр дүнтэй.

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан 40.3 мянган аж ахуйн нэгжийн 1.7 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байна. Эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 1.6 хувь, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 1.8 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байна. Харин эзэмшлийн хувьд 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг аж ахуйн нэгжийн 0.9 хувь, 33.4 ба түүнээс дээш хувийг нь эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 0.8 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай байна.


Зураг 40. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, гадаадын хөрөнгө оруулалттай эсэхээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар



2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгж 40 306

Гадаадын хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулалтын хувиар авч үзвэл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дийлэнх нь 80 ба түүнээс дээш хувийн гадаадын хөрөнгө оруулалттай байна.

Зураг 41. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийн хувь, гадаадын хөрөнгө оруулалтын хувиар, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар





4

БИЗНЕС ДЭХ УР ЧАДВАР ба

ЖЕНДЭР

- 4.1 Ажлын байран дахь жендэрийн ялгаатай байдал
- 4.2 Дундаж цалингийн жендэрийн ялгаатай байдал

4.1

АЖЛЫН БАЙРАН ДАХЬ ЖЕНДЭРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Бизнес захирлын болон эзэмшигчийн удирдлагын хүйсээр эрэгтэйчүүд давамгайлж байсан хандлага удирдлагын бус ур чадвар буюу ажлын байран дээр ч хадгалагдаж байна.


2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан 40.3 мянган аж ахуйн нэгжид нийт 419.6 мянган ажиллагчид ажиллаж байгаагаас 58.5 хувь нь эрэгтэй, 41.5 хувь нь эмэгтэй ажиллагчид бөгөөд ажиллагчдын хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэй ажиллагчид ногдох эрэгтэй ажиллагчдын тоо 141 байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлдэх оролцоо эрэгтэйчүүдийнхээс бага байгааг дагаад бизнесийн салбарт ч ажиллагчдын тооны хүйсийн тэнцвэр алдагдсан шинжтэй байна. Ажиллагчдын хүйсийн харьцаа тэнцвэртэй бус байгаа нь зөвхөн ажлын байран дахь жендэрийн тэгш бус байдлыг бий болгоод зогсохгүй нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд хүйсийн тэнцвэр алдагдахад нөлөөлөх боломжтой.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо сул байгааг эмэгтэйчүүдийн суралцах идэвх, тэдэнд оногддог хүүхэд, гэр бүлийн гишүүдийг асрах үүрэг, эрт тэтгэвэрт гарах зэрэгтэй холбоотой статистик үзүүлэлтээр тайлбарлаж болох юм. Түүнчлэн аж ахуйн нэгж хэлбэрээр бүртгүүлээгүй бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг эмэгтэйчүүдийн мэдээллийг нарийвчлан харах шаардлагатай.

Тухайлбал, Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогын дүнгээр үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн 39.6 хувь нь эмэгтэй захиралтай байхад хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 53.3 хувь нь эмэгтэй байна.

Өмнөх бүлгүүдэд дурдсан мэдээллүүдээс харахад эмэгтэй захирал, эзэмшигчтэй аж ахуйн нэгж эрэгтэй захирал, эзэмшигчтэй аж ахуйн нэгжээс олон ажиллагчидтай байх магадлал ерөнхийдөө бага байсан. Эмэгтэйчүүд ажлын байр бий болгож байгаа ч ажлын байр бий болгоход оруулсан хувь нэмэр нь бага байна. Эрэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж дунджаар 12 ажиллагчидтай байхад эмэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж дунджаар 8 ажиллагчидтай байна. Ажиллагчдын тоо нэмэгдэх тусам эмэгтэй удирдлагын оролцоо буурч байна.



Зураг 42. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын тоо, ажиллагчдын хүйсээр

245 330


174 226

Монгол Улсын иргэн эрэгтэй болон эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдийн хувьд ажиллагчдын хүйсийн харьцаа нь мөн ялгаатай байна. 2020 онд үйл ажиллагаа явуулсан эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн нийт ажиллагчдын 65.1 хувь нь эрэгтэй, 34.9 хувь нь эмэгтэй байна. Харин эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувьд нийт ажиллагчдын 44.1 хувь нь эрэгтэй, 55.9 хувь нь эмэгтэй байна.

Монгол Улсын иргэн эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувьд хүйсийн харьцаагаар эмэгтэй ажиллагчид давамгайлсан байгаа бол эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувьд хүйсийн харьцаагаар эрэгтэй ажиллагчид давамгайлсан, хүйсийн харьцаа илүү алдагдсан дүр зураг харагдаж байна.

Эмэгтэй захиралтай болон эмэгтэй эзэмшигчтэй аж ахуйн нэгжүүдийн хувьд ажиллагчдын хүйсийн харьцаа ерөнхийдөө ижил байна.

Зураг 43. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын тоо, ажиллагчдын хүйс, захирлын хүйс, эмэгтэй эзэмшигчээр




51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг

33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай

Зураг 44. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, ажиллагчдын тооны бүлгээр, салбараар, эрэгтэй захирлаар, дүнд эзлэх хувиар

Эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн эзлэх хувийг ажиллагчдын тооны бүлгээр болон салбараар нь ялгаж харахад салбар бүр онцлогтой боловч дийлэнхдээ аж ахуйн нэгж томрох тусам эмэгтэй захирлын оролцоо буурч байна.




Зочид буудал, зоогийн газар, үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслийн засвар, худалдаа гэсэн цөөн салбарын хувьд аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоо нэмэгдэхэд эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувь нэмэгдсэн байна.


Зураг 45. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, ажиллагчдын тооны бүлгээр, салбараар, эмэгтэй захирал, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар




Зураг 46. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын тоо, ажиллагчдын хүйс, захирлын хүйс, эмэгтэй эзэмшигчээр



Зураг 47. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын тоо, ажиллагчдын хүйс, захирлын хүйс, эмэгтэй эзэмшигчээр, бүсээр




Зураг 48. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын хүйсийн харьцаа, бүсээр



Аж ахуйн нэгжийн ажиллагчдын хүйсийн харьцаа аймаг, нийслэлээр мөн харилцан адилгүй байна. Хангайн бүс, Зүүн бүсэд 100 эмэгтэй ажиллагчдад 131 эрэгтэй ажиллагч ногдож буй бол Баруун бүс, Төвийн бүсэд 174-176 эрэгтэй ажиллагч ногдож байна.


Бүх бүсүүд болон Улаанбаатар хотод аж ахуйн нэгжийн ажиллагчдын хүйсийн харьцаагаар эрэгтэйчүүд давамгайлж байна. Улаанбаатар хотод энэ харьцаа 137 байна.

Зураг 49. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын хүйсийн харьцаа, ААН-ийн хариуцлагын хэлбэрээр



Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр хүйсийн харьцаа мөн ялгаатай. ХК, ТӨҮГ, ХХК-д хүйсийн харьцаа илүү өндөр байгаа бол хоршоо, нөхөрлөлийн хувьд хүйсийн харьцаа харьцангуй бага байна. Мөн захирлын хүйсээр ялгаж харвал эрэгтэй захиралтай бизнест хүйсийн харьцаа өндөр, эмэгтэй захиралтай бизнест хүйсийн харьцаа бага буюу харьцангуй тогтвортой байх хандлага ажиглагдаж байна.

Зураг 50. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан эрэгтэй захиралтай ААН-ийн нийт ажиллагчдад эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын эзлэх хувь, салбараар




Ажиллагчдын хүйсийн харьцаа ерөнхийдөө эрэгтэйчүүд давамгайлсан бөгөөд салбараар зарим ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, эрүүл мэнд, боловсролын салбарт бусад салбараас илүү эмэгтэй ажиллагчдын эзлэх хувь өндөр бөгөөд эрүүл мэнд, боловсрол, зочид буудал, зоогийн газар, санхүү, даатгал, бусад үйлчилгээ, бөөний болон жижиглэн худалдаа, урлаг, үзвэр, үл хөдлөх хөрөнгийн салбарын ажиллагчдын талаас илүү хувь нь эмэгтэйчүүд байна.

■ Эрэгтэй ажиллагч ■ Эмэгтэй ажиллагч

Зураг 51. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан эмэгтэй захиралтай ААН-ийн нийт ажиллагчдад эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын эзлэх хувь, салбараар

Ажиллагчдын
хүйсийн харьцаа

ЭМЭГТЭЙ ЗАХИРАЛТАЙ



Дийлэнх салбарын хувьд эрэгтэй ажиллагчид давамгайлж буй бөгөөд уул уурхай, барилгын салбарт эрэгтэйчүүдтэй харьцуулахад хамгийн бага эмэгтэйчүүд ажиллаж байна. Ажиллагчдын хүйсийн харьцаа хамгийн тэнцвэртэй салбар нь шинжлэх ухааны салбар юм.

Аж ахуйн нэгжийн ажиллагчдын хүйсийн харьцаа тэнцвэргүй байгаа нь хөдөлмөрийн зах зээл дээрх жендэрийн харьцаа алдагдсаныг илтгэх бөгөөд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжил сонголтын хүйсийн харьцааг анхаарч үзэх шаардлагыг дахин сануулж байна.

4.2

ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ЖЕНДЭРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ


Бизнесийн хөдөлмөрийн зах зээлд оролцож буй эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын дунд цалин хөлсний ялгаатай байдал ажиглагдаж байна. 2020 онд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдийн дундаж цалин 1.1 сая төгрөг бол эрэгтэй ажиллагчдын дундаж цалин 1.4 сая төгрөг, эмэгтэй ажиллагчдын дундаж цалин 912 мянган төгрөг байна. 2020 онд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн эрэгтэй ажиллагчдын дундаж цалин эмэгтэйчүүдийнхээс 49.0 хувиар илүү байна.


Эрэгтэй болон эмэгтэй ажиллагчдын ажилладаг салбарын ялгаатай байдал цалингийн ялгааны тодорхой хувийг тайлбарлах боломжтой. ДНБ-д илүү өндөр хувь эзэлдэг уул уурхай, хөдөө аж ахуй, боловсруулах салбарт эрэгтэйчүүд түлхүү ажилладаг. Мөн эрэгтэйчүүд илүү эрсдэл өндөр ажлын байруудад ажилладаг болохыг үйлдвэрлэлийн ослоор осолдогчдын статистик мэдээллээс (2016-2022 оны дунджаар үйлдвэрлэлийн ослоор осолдогчдын 71.6 хувь нь эрэгтэйчүүд байна) харах боломжтой⁸. Бизнесийн салбарын цалин хөлсний хүйсийн ялгааг ижил үнэлэмжтэй ажлын байр, албан тушаал, ур чадварын хувьд нарийвчлан судлах шаардлагатай.

Захирлын хүйсээр авч үзвэл эмэгтэй захиралтай аж ахуйн нэгж эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжтэй харьцуулахад дунджаар 15.4 хувиар өндөр цалин олгож байна.


⁸ Үйлдвэрлэлийн ослоор осолдогчдын статистик мэдээлэл, ҮСХ

Зураг 52. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын дундаж цалин, ажиллагчдын хүйс, захирлын хүйсээр, мянган төгрөг






Зураг 53. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын дундаж цалин, ажиллагчдын хүйс, захирлын хүйс, ажиллагчдын тооны бүлгээр, мянган төгрөг



Цалин хөлсний хүйсийн ялгаатай байдал нь тухайн хүйсийн орлогын түвшин, амьдралын чанар, санхүүгийн хараат бус байдал, цаашлаад тэтгэврийн хэмжээ зэрэг олон үзүүлэлтэд нөлөөлөх тул Монгол Улсын цалингийн хүйсийн тэнцвэрт бус байдлыг нарийвчлан судлах, анхаарч бодлогод тусгах шаардлагатай.

Зураг 54. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн ажиллагчдын дундаж цалин, ажиллагчдын хүйс, захирлын хүйс, борлуулалтын орлогын бүлгээр, мянган төгрөг





5

ТЕХНОЛОГИ, ИННОВАЦ, СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ

ба

ЖЕНДЭР

- 5.1 Технологи ашиглалт ба жендэрийн ялгаатай байдал
- 5.2 Инновац нэвтрүүлэлт ба жендэрийн ялгаатай байдал
- 5.3 Судалгаа хөгжүүлэлт ба жендэрийн ялгаатай байдал

5.1

ТЕХНОЛОГИ АШИГЛАЛТ БА ЖЕНДЭРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ


Бизнесийн салбарын хөгжил нь технологи, инновац хийгээд судалгаа хөгжүүлэлтгүй урагшлах боломжгүй. Бизнесийн салбар нь өөрөө эдийн засгаа түүчээлэн шинэ технологи, ноу-хау бүтээж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх замаар нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулдаг.

Аж ахуйн нэгжийн энэ удаагийн тооллогод бизнесийн салбарын технологи, инновац, судалгаа хөгжүүлэлтийн талаар мэдээлэл бүрдүүлж эхэлсэн нь цаашид технологи, мэдлэгийн салбарын өгөгдлийн сан үүсгэх, түүнд суурилсан бодлого тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.


2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан 40.3 мянган аж ахуйн нэгжийн 81.8 хувь буюу 33.0 мянга нь үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашиглаж байна. Аж ахуйн нэгжийн захирлын хүйсээр харвал эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 80.9 хувь, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 83.2 хувь нь үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашиглаж байна. Эзэмшигчийн хувьд эмэгтэй эзэмшигчтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашиглах нь эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдтэй ерөнхийдөө ижил байна.

Үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг 33.0 мянган аж ахуйн нэгжийн 92.5 хувь нь нийт ажиллагчдынх нь 9 хүртэл хувь компьютер тогтмол ашиглаж байна. Ажиллагчдын ажилдаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашиглаж буй байдалд эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувьд бага зэрэг давамгайл байгаа юм. Энэ нь салбарын онцлогоос хамаарч болох юм.

Зураг 55. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан, үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг ААН-ийн тоо, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар



Зураг 56. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаандаа компьютер тогтмол ашигладаг ажиллагчдын хувиар, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар



Аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого болон ажиллагчдын тооны хэмжээгээр харьцуулж харвал аж ахуйн нэгж томрох тусам үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашиглах нь нэмэгдэж байна.

2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийн 95.2 хувь нь үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг бол 200 ба түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжийн 97.7 хувь нь компьютер, ухаалаг төхөөрөмж ашиглаж байна. Эмэгтэй захиралтай аж ахуйн нэгж эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжтэй харьцуулахад компьютер, ухаалаг төхөөрөмж ашиглах нь ялимгүй илүү байна.


Эрэгтэй захиралтай

Эмэгтэй захиралтай

51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг


33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай

Зураг 57. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг хувиар, ажиллагчдын тооны бүлгээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр



- Бүгд
- Эрэгтэй захиралтай
- Эмэгтэй захиралтай
- 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг
- 33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай

Зураг 58. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг хувиар, борлуулалтын орлогын бүлгээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр



Бүгд
 Эрэгтэй захиралтай
 Эмэгтэй захиралтай
 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг
 33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай


2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан 40.3 мянган аж ахуйн нэгжийн 70.1 хувь нь буюу 28.2 мянга нь үйл ажиллагаандаа сүлжээ ашиглаж байна. Эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа сүлжээ ашиглах нь эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжтэй харьцуулахад арай илүү байна.

2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн 57.3 хувь нь үйл ажиллагаандаа интернэт тогтмол ашиглаж байна. Интернэт тогтмол ашиглалтын хувиар мөн эмэгтэй захиралтай аж ахуйн нэгж арай илүү байна.


Цаашилбал 2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн 11.1 хувь нь буюу 4.5 мянга нь өгөгдлийн сантай, мөн 11.9 хувь буюу 4.8 мянга нь дата сервертэй байна.

Мэдээлэл, холбооны салбарын аж ахуйн нэгж хамгийн өндөр буюу 29.2 хувь нь дата сервертэй бөгөөд тус салбарын эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 29.9 хувь нь дата сервертэй байхад эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 27.3 хувь нь дата сервертэй байгаа юм. Эндээс харвал эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд өгөгдлийн боломжуудыг илүү ашиглах хандлагатай байна.


Зураг 59. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаандаа сүлжээ ашигладаг эсэхээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар




Зураг 60. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, үйл ажиллагаандаа интернэт тогтмол ашигладаг эсэхээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар



Зураг 61. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, өгөгдлийн сантай эсэхээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар



Зураг 62. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, дата сервертэй эсэхээр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар



- Бүгд
- Эрэгтэй захиралтай
- Эмэгтэй захиралтай
- 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг
- 33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай

5.2

ИННОВАЦ НЭВТРҮҮЛЭЛТ БА ЖЕНДЭРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ


2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан 58.8 мянган аж ахуйн нэгжийн 8.0 хувь буюу 4.4 мянган аж ахуйн нэгж 2018-2021 онд шинэ эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг нэвтрүүлжээ. Захирлын хүйсийн ялгаагаар авч үзвэл эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувьд эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжтэй харьцуулахад инновац нэвтрүүлэлт ялимгүй өндөр байна.

Инновац нэвтрүүлэлтийн төрлийн хувьд аж ахуйн нэгжүүд мэдээлэл, харилцааны холбооны системийн инновац, зохион байгуулалт, менежментийн инновацыг хамгийн түлхүү нэвтрүүлсэн байна. Инновац нэвтрүүлсэн 4.4 мянган аж ахуйн нэгжийн 59.9 хувь нь эрэгтэй захиралтай, 40.1 хувь нь эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд юм.


Зураг 63. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, 2018-2021 онд шинээр эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг нэвтрүүлсэн хувиар, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр

2018-2021 онд шинээр эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг нэвтрүүлсэн

2018-2021 онд бизнесийн үйл явцын инновац нэвтрүүлсэн



Зураг 64. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан, бизнесийн үйл явцын инновац нэвтрүүлсэн ААН-ийн тоо, инновацын төрлөөр, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, давхардсан тоогоор, дүнд эзлэх хувиар




Эрэгтэй захиралтай

Эмэгтэй захиралтай

51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг


33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай

Зураг 65. 2018-2021 онд шинээр эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг нэвтрүүлсэн МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, салбараар




Зураг 65. Үргэлжлэл/ 2018-2021 онд шинээр эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг нэвтрүүлсэн МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, салбараар

2018-2021 онд шинээр эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг нэвтрүүлсэн байдлыг салбараар авч үзвэл эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн захиралтай аж ахуйн нэгжүүд худалдаа болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарт илүү инновац нэвтрүүлсэн байна. Эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдтэй харьцуулахад илүү инновац нэвтрүүлэх хандлагатай боловч эрүүл мэнд, боловсролын салбарт эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд инновац нэвтрүүлэлтээр эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдээс илүү байна.



Зураг 66. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн инновацын үйл ажиллагааны 2020 оны зардал, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, тэрбум төгрөг


2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүд 2020 онд инновацын үйл ажиллагаандаа нийт 213.2 тэрбум төгрөг зарцуулжээ. 2020 онд нийт 1.9 мянган аж ахуйн нэгж инновацын үйл ажиллагааны зардал гаргасан буюу нэг аж ахуйн нэгж инновацын зардалдаа дунджаар 112.1 сая төгрөг зарцуулж байна.



- Бүгд
- Эрэгтэй захиралтай
- Эмэгтэй захиралтай
- 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг
- 33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай

Зураг 67. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан нэг ААН-д ногдох инновацын үйл ажиллагааны 2020 оны зардал, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, сая төгрөг

Эмэгтэй захиралтай, тэр дундаа эмэгтэй эзэмшигчтэй аж ахуйн нэгж инновацын үйл ажиллагаанд илүү өндөр дүнтэй хөрөнгө оруулалт хийж байна. Эрэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж инновацын үйл ажиллагаандаа дунджаар 48.8 сая төгрөг зарцуулсан бол эмэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж дунджаар 205.1 сая төгрөг зарцуулжээ. 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг аж ахуйн нэгжүүд 268.4 сая төгрөг зарцуулжээ.




5.3

СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ БА ЖЕНДЭРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Бизнесийн судалгаа хөгжүүлэлтийн ажил хэрэгжүүлэх хандлага ерөнхийдөө бага байдаг. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан 55.8 мянган аж ахуйн нэгжийн 2.1 хувь буюу 1.2 мянган аж ахуйн нэгж 2018-2021 онд судалгаа хөгжүүлэлтийн ажил хийжээ.


2018-2021 онд нийт 3.1 мянган суурь судалгааны ажил, 2.4 мянган хэрэглээний судалгааны ажил, 4.1 мянган туршилт хөгжүүлэлтийн ажил тус тус хийгджээ. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын хувьд эрэгтэй захиралтай аж ахуйн нэгж эмэгтэй аж ахуйн нэгжтэй харьцуулахад илүү байна.

Зураг 68. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан, 2018-2021 онд судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, дүнд эзлэх хувиар




- Бүгд
- Эрэгтэй захиралтай
- Эмэгтэй захиралтай
- 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг
- 33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай


Зураг 69. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан, 2018-2021 онд судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, салбараар, давхардсан тоогоор



Зураг 70. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын тоо, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр




Зураг 71. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын 2020 оны зардал, тэрбум төгрөг, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр



2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүд 2020 онд судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагаандаа нийт 10.3 тэрбум төгрөг зарцуулжээ. 2020 онд нийт 1.2 мянган аж ахуйн нэгж судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагааны зардал гаргажээ. Нэг аж ахуйн нэгж судалгаа хөгжүүлэлтийн зардалдаа дунджаар 8.9 сая төгрөг зарцуулсан байна.

- Бүгд
- Эрэгтэй захиралтай
- Эмэгтэй захиралтай
- 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг
- 33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай

Зураг 72. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан нэг ААН-д ногдох судалгаа хөгжүүлэлтийн ажлын 2020 оны зардал, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр, сая төгрөг



Эрэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагаандаа дунджаар 10.0 сая төгрөг зарцуулсан бол эмэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж дунджаар 7.0 сая төгрөг зарцуулжээ.


Зураг 73. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан нэг ААН-ийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын 2020 оны зардлын борлуулалтын орлогод эзлэх хувь, захирлын хүйсээр, эмэгтэй эзэмшигчээр



51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг ● Эрэгтэй захиралтай ●
 33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай ○ Эмэгтэй захиралтай ●


Зураг 74. 2018-2021 онд үйл ажиллагаа явуулсан, 2018-2020 онд судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, захирлын хүйсээр, салбараар

Зураг 75. 2020 онд үйл ажиллагаа явуулсан, ISO стандартыг нэвтрүүлсэн МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, захирлын хүйсээр, салбараар



Эрэгтэй захиралтай ● Эмэгтэй захиралтай

Зураг 76.2020 онд үйл ажиллагаа явуулсан, тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг МУ-ын иргэнээр удирдуулсан ААН-ийн тоо, захирлын хүйсээр, салбараар





6

БИЗНЕСИЙН ТӨЛӨВ, ХАНДЛАГА ба

ЖЕНДЭР

- 6.1 Бизнес эрхлэхэд тулгарч буй бэрхшээл ба жендэрийн ялгаатай байдал
- 6.2 Ковид-19 цар тахлын нөлөө ба жендэрийн ялгаатай байдал
- 6.3 Бизнесийн төлөв, хандлага ба жендэрийн ялгаатай байдал


6.1

БИЗНЕС ЭРХЛЭХЭД ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ БА ЖЕНДЭРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ


Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ 13.7 хувь нь өссөн, 51.3 хувь нь өөрчлөгдөөгүй бол 35.0 хувь нь буурсан байна.

Харин аж ахуйн нэгжийн орлого 18.2 хувь нь өссөн, 37.5 хувь нь өөрчлөгдөөгүй бол 44.4 хувь нь буурсан байна.


Зураг 77. Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ 2020 оны эхний 9 сартай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн бэ?



Зураг 78. Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгжийн орлого 2020 оны эхний 9 сартай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн бэ?




Зураг 79. Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгжийн хэрэглэгчдийн захиалгын хэмжээ 2020 оны эхний 9 сартай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн бэ?



Харин хэрэглэгчдийн захиалгын хувьд аж ахуйн нэгжүүдийн 12.2 хувь нь өссөн, 48.2 хувь нь өөрчлөгдөөгүй бол 39.6 хувь нь буурсан байна. Аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоо 7.3 хувь нь өссөн, 76.6 хувь нь өөрчлөгдөөгүй бол 16.1 хувь нь буурсан байна.

Зураг 80. Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоо 2020 оны эхний 9 сартай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн бэ?



6.2

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ БА ЖЕНДЭРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Монгол Улсад Ковид-19 цар тахлын халдварын анхны тохиолдол 2020 оны 3-р сарын 10-ны өдөр бүртгэгдсэнээс хойш 2 жил гаруй хугацаа өнгөрөөд байна. Энэ хугацаанд хэд хэдэн удаа хөл хорио тогтоож, бизнесийн үйл ажиллагаа тасалдах, бизнесийн үйл ажиллагааны загварууд цахим хувилбарт шилжих, аж ахуйн нэгжийн ажиллагчид гэрээсээ ажиллах гэх мэт олон өөрчлөлтүүд бий болсон.

2020 онд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүд хатуу хөл хорионы үед үйл ажиллагаагаа хэрхэн явуулж байсан талаар тодруулахад нийт аж ахуйн нэгжийн 12.5 хувь нь хэвийн явуулж байсан бол 59.1 хувь нь зайнаас болон хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байсан байна. Харин нийт аж ахуйн нэгжийн 28.4 хувь нь үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон байна.

Аж ахуйн нэгжийн захирлын хүйсээр авч үзвэл эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 11.2 хувь нь хатуу хөл хорионы үед үйл ажиллагаагаа хэвийн явуулж байсан бол эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 14.4 хувь нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж байсан байна. Энэ нь эрэгтэй, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа голлон явуулдаг салбарын онцлог, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгж технологийн хэрэглээгээр давуу байдаг зэргээс шалтгаалсан байж болох юм.

Эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 30.1 хувь нь үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон бол эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 25.9 хувь нь үйл ажиллагаагаа бүрэн зогсоох шийдвэрт хүрч байжээ.

2021 оны эхний 9 сард аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Ковид-19 цар тахал хэрхэн нөлөөлснийг тодруулахад 86.0 хувьд нь сөргөөр нөлөөлсөн бол 7.2 хувьд нь эерэгээр нөлөөлсөн байна.

Эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувьд цар тахлын нөлөө сөргөөр нөлөөлсөн хувь эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжтэй харьцуулахад өндөр байна.



Бүгд



Эрэгтэй захиралтай



Эмэгтэй захиралтай




51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг




33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай

Зураг 81. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгж хатуу хөл хорионы үед үйл ажиллагаагаа хэрхэн явуулсан бэ?




Зураг 82. 2020 онд үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгжийн 2021 оны эхний 9 сарын үйл ажиллагаанд Ковид-19 цар тахал яаж нөлөөлсөн бэ?




Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдээс хатуу хөл хориотой холбоотой ямар хүндрэл, бэрхшээл үүссэн талаар тодруулахад 37.4 хувь нь ажлын байраа хадгалахад хүндрэл учирсан, 19.8 хувь нь төр засгаас хэрэгжүүлж буй шийдвэрүүдийн ойлгомжгүй, уялдаагүй байдлаас болж хүндрэл үүссэн, 17.3 хувь нь ажиллагчдын цалин тавихад хүндрэл үүссэн талаар дурджээ.

Зураг 83. Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгжийн бизнест хатуу хөл хориотой холбоотой үүссэн хүндрэл бэрхшээл юу вэ?



Зураг 83. /үргэлжлэл/ Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгжийн бизнест хатуу хөл хориотой холбоотой үүссэн хүндрэл бэрхшээл юу вэ?



Түүхий эдийн олдоцтой холбоотой асуудал аж ахуйн нэгжийн 6.7 хувьд нь үүссэн бол зээлийн эргэн төлөлттэй холбоотой асуудал 5.8 хувьд нь үүссэн байна. Захирлын хүйсийн ялгаагаар авч үзэхэд ерөнхийдөө ижил бөгөөд ажиллагчдын цалин тавих, түүхий эдийн олдоцтой холбоотой хүндрэл эрэгтэй захирлуудад арай илүү тулгарсан бол зээлийн эргэн төлөлт, түрээсийн төлбөртэй холбоотой хүндрэл эмэгтэй захирлуудад бага зэрэг илүү тулгарсан байна.


6.3

БИЗНЕСИЙН ТӨЛӨВ, ХАНДЛАГА БА ЖЕНДЭРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ


Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдийн 2022 оны бизнесийн хүлээлтийг тодруулахад 45.0 хувь нь эерэг хүлээлттэй, 10.2 хувь нь сөрөг хүлээлттэй байна.

Захирлын хүйсээр хүлээлтийг тодруулахад эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 44.7 хувь нь эерэг хүлээлттэй бол эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн 45.5 хувь нь эерэг хүлээлттэй байна.


Зураг 84. Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Танай аж ахуйн нэгж ирэх онд бизнесийн үйл ажиллагаандаа ямар үр дүнг хүлээж байна вэ?



ХЭВИЙН



САЙЖИРНА




МУУДНА

- Бүгд
- Эрэгтэй захиралтай
- Эмэгтэй захиралтай
- 51 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг
- 33.4 ба түүнээс дээш хувийг эмэгтэй хүн эзэмшдэг, эмэгтэй захиралтай

Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүд бизнесийн салбарт анхаарвал зохих асуудлуудыг авлига, хүнд суртлыг бууруулах, зээлийн хүүг бууруулах, НДШ-ийн хувь хэмжээг бууруулах гэж тодорхойлжээ. Авлига, хүнд суртлын асуудлыг эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд илүү онцолсон бол НДШ-ийн хувь хэмжээ өндөр байгаа тухай эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд илүү онцолжээ.

Зураг 85. Тооллогын өмнөх 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан МУ-ын иргэнээр удирдуулсан ААН: Цаашид аж ахуйн нэгжийн бизнесийг хөгжүүлэхэд төрийн бодлогын түвшинд нэн тэргүүнд ямар арга хэмжээ авбал зохистой вэ?



ДУГНЭЛТ

Монгол Улсад бизнес эрхлэгчдийн хүйсээр ангилсан албан ёсны тодорхойлолт болон бизнесийн хүйсээр ангилсан нэгдсэн өгөгдлийн сан хараахан бүрдээгүй ч Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллого нь аж ахуйн нэгжийн захирлын хүйсээр өгөгдлийг ангилах замаар анх удаа бизнес эрхлэлтийн жендэрийн ялгаатай байдлыг өргөн хүрээнд үнэлэх боломж олгосон юм.

Аж ахуйн нэгжийг захирлын хүйсээр ангилан тодорхойлбол бизнесийн салбарт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд аль аль нь тодорхой хувь нэмэр оруулж буй ч оролцооны хувьд ялгаа ажиглагдаж байна.

Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн бизнес эрхлэх шийдвэр гаргалт, бизнес эрхлэх боломж, цаашлаад бизнесээ амжилттай авч явахад олон хүчин зүйлс нөлөөлөх боломжтой. Үүнд, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин, хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо, гэр бүлийн болон нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, тогтсон дүр, нийгэм, соёлын хэвшмэл ойлголтууд, төрөөс хэрэгжүүлж буй бодлого гээд олон зүйлийг дурдаж болно.

Бизнесийн салбарт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцооны үндсэн ялгаа нь хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо, бизнес эрхлэх идэвх болон шалтгаан, салбарын ялгаатай сонголт болон бизнесийн гүйцэтгэл, үр дүнгийн үзүүлэлтүүдэд илэрч байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүст хөдөлмөрийн зах зээлд оролцох, улмаар амжилттай бизнес эрхлэх, цаашлаад хөгжлийн үр шимээс хүртэх сонголт хийх боломж ялгаатай байна гэж үзэж болохоор байна.

1. БИЗНЕС ЭРХЛЭХ ИДЭВХ ХҮЙСИЙН ХУВЬД ЯЛГААТАЙ БАЙНА.

Монгол Улсад хүн амын хүйсийн харьцаа харьцангуй тэнцвэртэй боловч хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо, бизнес эрхлэх идэвхийн хувьд эмэгтэйчүүд сул байна. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэйчүүдийнхээс 15 нэгж хувиар бага, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн эмэгтэй захирлын хувь эрэгтэй захирлуудынхаас 21 нэгж хувиар тус тус бага байна.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нөхөн үржихүйн онцлог болон нийгэмд тодорхойлогдсон ажил, үүргийн ялгаа нь тэдний бизнес эхлүүлэх сонголт төдийгүй бизнесээ амжилттай авч явахад нөлөөлж байна.

Хүн амын цаг ашиглалтын судалгааны үр дүнгээс⁹ харахад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1-8 дахин их хугацааг гэрийн ажил, хүүхэд асрах гэх мэт

⁹ Цаг ашиглалтын судалгаа, УСХ, 2019 он

хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байна. Эмэгтэйчүүд боловсролын түвшингээр эрэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр, боловсролд илүү цаг зарцуулдаг ч хөдөлмөрийн зах зээлд оролцох үед эрэгтэйчүүдтэй адил цагийг хөдөлмөр эрхлэхэд зарцуулах боломж нь хязгаарлагдаж эхэлдэг. Энэ нь эмэгтэйчүүд албан тушаал ахих, тууштай карьер өсгөх, бизнесийн салбарт хангалттай туршлага хуримтлуулах боломжийг хязгаарлаж байна.

Бизнес эрхлэх идэвх нь хөдөлмөрийн зах зээлд оролцохоос эхлэлтэй. Эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээлд оролцох эсэх сонголт хийх боломж эрэгтэйчүүдээс ялгаатай бөгөөд хөдөлмөрийн зах зээлд оролцохгүй байх нь сонголтоос илүү хэрэгцээнд тулгуурласан буюу гэр бүлийн болон нийгмийн өмнө хүлээх үүрэгт тулгуурласан шийдвэр байж болохоор байна. Эмэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөр эрхлэхийнхээ хажуугаар орлого олохын тулд албан бус хөдөлмөр эрхлэх, хувиараа хөдөлмөр эрхлэх нь түгээмэл байна.

Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн бизнес эрхлэхэд зарцуулах боломжит цаг ялгаатай буюу эмэгтэйчүүд хүүхэд, гэр бүлийн гишүүдийг асрах, гэрийн ажил хийх гэх мэт хөлсгүй хөдөлмөрийн дийлэнхийг үүрдэг учраас эмэгтэйчүүдийн эзэмшиж, ажиллуулдаг бизнесүүдийн ихэнх нь бичил эсвэл жижиг бизнесүүд байдаг.

2. БИЗНЕСТ МАНЛАЙЛЛЫН НҮҮР ЦАРАЙ ЭРЭГТЭЙ ХҮЙСЭЭР ТОДОРХОЙЛОГДОЖ БАЙНА.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл болон бизнесийн салбар дахь оролцоо сул байгаагаас гадна эмэгтэйчүүдийн эзэмшдэг бизнесүүдийн амжилт нь эрэгтэйчүүдийнхээс хоцорч байна. Бизнес эрх мэдэл нэмэгдэх тусам эрэгтэйчүүдийн оролцоо давамгайлж байна.

Эрэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж 2.0 тэрбум төгрөгийн дундаж борлуулалтын орлого бүрдүүлсэн бол эмэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгж үүнээс 2 дахин бага буюу 1.0 тэрбум төгрөгийн дундаж борлуулалтын орлого бүрдүүлжээ. 2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой том аж ахуйн нэгжийн хувьд хүйсийн ялгаа улам гүнзгийрч эрэгтэй захиралтай аж ахуйн нэгж 71.6 хувийг бүрдүүлж байхад эмэгтэй захиралтай аж ахуйн нэгж 28.4 хувийг бүрдүүлж байна.

Эрэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгжийн ажиллагчдын дундаж тоо 12 байхад эмэгтэй захиралтай нэг аж ахуйн нэгжийн хувьд 8 байна.

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулсан хугацааны хувьд эрэгтэй, эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд ерөнхийдөө ойролцоо, эмэгтэйчүүд арай илүү тууштай байгаа ч эрэгтэй захиралтай аж ахуйн нэгж 2 дахин илүү өндөр орлого олж, дунджаар 4 ажиллагч илүү ажиллуулж байна.

Түүнчлэн салбарын хувьд эрэгтэйчүүдийн эрхэлдэг бизнес нь илүү өндөр ашиг олохуйц эдийн засгийн тэргүүлэх салбаруудад давамгайлж буй юм.

Эдгээр мэдээллүүд нь эрэгтэйчүүд бизнесийн салбарт эмэгтэйчүүдээс илүү амжилттай ажиллах магадлал өндөр, ашиг олох боломж их байдаг гэдэг хэвшмэл ойлголтыг улам гүнзгийрүүлж байна.

3. ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ АЛЬ Ч БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД САНХҮҮЖИЛТИЙН АСУУДАЛ ТУЛГАРДАГ, ГЭХДЭЭ ЯЛГААТАЙ ШИЙДЭЛ ХЭРЭГТЭЙ.

2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн 37.0 хувь нь зээлтэй, 63.0 хувь нь зээлгүй байна. Зээлийн эх үүсвэрээр санхүүжилт бүрдүүлэх энэ хандлагыг захирлын хүйсээр авч үзвэл ерөнхийдөө тэнцвэртэй. Мөн санхүүжилт буюу зээлэнд хамрагдаж чадаагүй шалтгааныг тодруулахад ерөнхийдөө ижил хүндрэлүүд тулгардаг. Гэсэн хэдий ч Монголбанкны ЖДҮ эрхлэгчдийн зээлийн мэдээллээс харахад эмэгтэйчүүдийн авч буй зээлийн хэмжээ эрэгтэйчүүдийнхээс бага байгаа нь анхаарал татаж байна.

Эмэгтэйчүүдийн эрхэлж буй бизнес нь орлогын хувьд эрэгтэйчүүдийнхээс бага байдаг бөгөөд ижил хугацаанд үйл ажиллагаа явуулсан ч эрэгтэйчүүдийнхтэй ижил хэмжээнд томорч чадахгүй байна. Эмэгтэйчүүдийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой судалгаануудаас харахад зээлийн барьцаа хөрөнгийн шаардлагыг хангахуйц хөрөнгө эзэмших нь бага тул хүссэн хэмжээний зээлэнд хамрагдах, бизнесээ хангалттай өргөжүүлэхэд шаардлагатай хэмжээний санхүүжилт олж авахад хүндрэлтэй байдаг. Мөн хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 53.3 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж буй ч бизнесээ албан болгох, хангалттай томруулах боломж эрэгтэйчүүдтэй харьцуулахад сул байна.

Бизнесийн салбарыг дэмжихэд санхүүжилтийн асуудал хамгийн чухал бөгөөд эрэгтэй болон эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүдийн зээлэнд хамрагдалтын түвшин ерөнхийдөө ижил, тулгарч буй асуудал нь ч төстэй боловч зээлийн дүн болон хугацааны хувьд ялгаатай байгааг анхаарч бизнесийн санхүүжилтийн асуудлыг шийдэхдээ эрэгтэй болон эмэгтэй бизнес эрхлэгчийн онцлог, ялгаатай хэрэгцээнд тохирсон ялгаатай бодлого, санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх нь илүү үр дүнтэй.

4. БИЗНЕСИЙН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ХҮЙСИЙН БОЛОН ЦАЛИН ХӨЛСНИЙ ТЭНЦВЭРТ БУС БАЙДАЛ ТОДОРХОЙ САЛБАРУУДАД ИХЭЭХЭН АЛДАГДСАН.

Бизнес эрхлэгчдийн дунд эрэгтэй, эмэгтэй хүйсийн оролцоо ялгаатай байгаагаас гадна бизнесийн салбарт ажиллах хүчний хүйсийн тэнцвэр алдагдаад байна.

Нийт дүнгээр авч үзвэл эрэгтэй болон эмэгтэй ажиллагчдын харьцаа тус тус харгалзан 58.5 хувь болон 41.5 хувь байна. Харин аж ахуйн нэгжийн захирлын хүйсээр болон салбараар харвал ажиллагчдын хүйсийн харьцааны зөрүүтэй байдал бүр илүү нэмэгдэж байна. Эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжийн хувьд ажиллагчдын хүйсийн тэнцвэрт бус байдал эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжтэй харьцуулахад өндөр байна.

Ажиллагчдын салбарын сонголт нь аль хэдийн жендэрийн хувьд тэгш бус буюу эрэгтэйчүүд ажилладаг салбар, эмэгтэйчүүд ажилладаг салбар тусдаа мэт дүр зураг харагдаж байна. Уул уурхай, тээвэр, агуулах, барилга, хөдөө аж ахуй гэх мэт эдийн засгийн тэргүүлэх салбаруудад ажиллагчдын 70-аас дээш хувь нь эрэгтэй ажиллагчид байхад эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллагчдын 70-аас илүү хувь нь эмэгтэй ажиллагчид байна.

Мэргэжил сонголт, салбарын сонголтод хүйсийн ялгаа, хэвшмэл ойлголтууд хадгалагдсаар буй бөгөөд эрэгтэйчүүд нэмүү өртөг өндөртэй салбаруудад давамгайлдаг хэдий ч хөдөлмөрийн аюулгүй байдлын хувьд эрсдэл өндөртэй салбаруудад ажиллаж буйг мөн анхаарах шаардлагатай.

Бизнесийн салбарт ажиллагчдын хүйсийн энэхүү ялгаатай байдал нь эрэгтэй, эмэгтэй бизнес эрхлэлтэд шууд нөлөөлөх хүчин зүйл юм. Ажиллагчдын хүйсийн харьцаа тэнцвэртэй бус байгаа нь зөвхөн ажлын байран дахь жендэрийн тэгш бус байдлыг бий болгоод зогсохгүй нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд хүйсийн тэнцвэр алдагдахад нөлөөлөх боломжтой.

Цаашилбал дундаж цалингийн түвшин хүйсийн хувьд зөрүүтэй байна. 2020 онд үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэнээр удирдуулсан аж ахуйн нэгжийн эрэгтэй ажиллагчдын дундаж цалин эмэгтэйчүүдийнхээс 49.0 хувь өндөр байна. Цалингийн түвшний ялгаатай байдал нь салбар, мэргэжлийн онцлогтой холбоотой хэдий ч эмэгтэйчүүдийн орлого, эдийн засгийн хараат бус байдалд нөлөөлөх чухал асуудал тул жендэрийн хувьд цалин хөлсний тэгш бус байдалд зайлшгүй анхаарах шаардлагатай юм.

ЗӨВЛӨМЖ

Монгол Улс 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг баталж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар анхааран авч үзэж, бодлого, хөтөлбөрүүдэд тодорхой тусгаж өгсөн байна. Гэсэн хэдий ч бизнесийн салбарыг тусгайлан авч үзвэл жендэрийн ялгааг нарийвчлан үнэлэх, жендэрийн мэдрэмжтэй, чиглэсэн бодлого хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгцээ, шаардлага байсаар байна.

Бизнесийн орчинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлснээр дан ганц эмэгтэйчүүд үр шим хүртэх бус хүн амын хөдөлмөр эрхлэлт нийтээрээ нэмэгдэх, гэр бүлийн орлого нэмэгдэх, эмэгтэйчүүд ихэвчлэн хийдэг хөлсгүй хөдөлмөр хөлстэй хөдөлмөрт шилжих эдийн засгийн болон нийгмийн үр өгөөжтэй. Бизнесийн салбарыг хөгжүүлэх нь улс орны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, иргэдийн амьжиргааны баталгааг хангах боломж юм.

1. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийг хөдөлмөрийн зах зээлд түлхүү оролцуулахын тулд бодлогын хувьд эмэгтэйчүүдэд оноосон нийгмийн үүргүүдийг хөнгөвчлөх, орлуулах чанартай үйлчилгээ бий болгох замаар эмэгтэй хүний үүргийг эдийн засгийн үнэлэмжтэй болгох нь үр дүнтэй. Хүн амын өсөлтийг дэмжихийн хажуугаар хүүхэд асрахтай холбоотой үйлчилгээг сайжруулах, эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн үүргээ биелүүлэхийн сацуу нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжийг нэмэгдүүлэх бодлого шаардлагатай.

Нөгөөтэйгүүр аж ахуйн нэгж хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн дунд эмэгтэйчүүдийн оролцоо бага байгаа ч албан бус болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд эмэгтэйчүүдийн оролцоо эсрэгээрээ өндөр байгааг анхаарч авч үзэх нь зүйтэй. Энэ нь эмэгтэйчүүдэд бизнесээ албан болгох, бизнесээ томруулахад тулгардаг тодорхой хүндрэлүүдийг олж тогтоохоос эхэлнэ. Эмэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөр эрхлэхийн хажуугаар амьдралын шаардлагаар хувиараа хөдөлмөр эрхлэхээс өөр аргагүй байдалд хүрэх нь их байдаг. Эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэх, бизнес эрхлэх, цаашлаад шийдвэр гаргах түвшинд оролцох оролцоог нэмэгдүүлэхийн тулд тэдний сонголт хийх боломжийг нээх шаардлагатай.

Хүүхэд, гэр бүлийн гишүүдийг асрах үүрэг хүлээсэн эмэгтэйчүүдэд зориулсан уян хатан нөхцөл бүхий ажлын байруудыг ихээр бий болгох нь эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээлд огт оролцохгүй байх, ажил мэргэжлийн хувьд тогтвортой туршлага хуримтлуулах боломжоо алдахаас сэргийлэхэд тустай.

Хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхгүйгээр бизнесийн салбарын хүйсийн тэгш оролцоог хангах боломжгүй юм.

2. ЭМЭГТЭЙЧҮҮД БИЗНЕСЭЭ АЛБАЖУУЛАХ, ТОМРУУЛАХАД ТУСЛАХ

Эмэгтэйчүүдийн бизнесийн салбар дахь оролцоог нэмэгдүүлэхээс гадна тэдний бизнесийг чадавхжуулахад анхаарах шаардлагатай байна. Эмэгтэйчүүд ихэвчлэн бичил бизнес, хувиараа хөдөлмөр эрхэлж буй тул тэднийг албан ёсны бүртгэлтэй аж ахуйн нэгжийн хэлбэрт шилжүүлэх, бичил, жижиг аж ахуйн нэгжүүдийн хувьд бизнесээ өргөжүүлэхэд нь чиглэсэн үр дүнтэй бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй.

Албан бус секторт ажиллаж буй эмэгтэйчүүд бүртгэлд хамрагддаггүйн улмаас аливаа төсөл, хөтөлбөр, төрийн дэмжлэгт хамрагдах боломж нь хязгаарлагдмал байдаг. Тэдгээр эмэгтэйчүүдийг эхлээд бүртгэлжүүлэх, цаашлаад мэдээллээр хангах замаар бүртгэлтэй эмэгтэй бизнес эрхлэгчдийг нэмэгдүүлж, боломжит төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдах боломжийг нээж өгөх нь зүйтэй.

Арилжааны голлох банкууд эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлж байгаа ч энэхүү санхүүгийн боломжуудыг эмэгтэй бизнес эрхлэгчдэд хүргэх, энэ талаарх мэдлэг, мэдээллийг түгээх, холбох механизмыг сайжруулах шаардлагатай.

Эмэгтэй бичил бизнес эрхлэгчдийн чадавхыг бүрэн дүүрэн нээхийн тулд бичил бизнес эрхлэгчдэд чиглэсэн дэмжлэгийг бэхжүүлэх, үүнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харьцангуй нөхцөл байдлыг харгалзсан бодлого хэрэгжүүлэх хэрэгцээ бий.

3. БИЗНЕСИЙН САЛБАРЫН ХҮЙСЭЭР АНГИЛСАН НАРИЙВЧИЛСАН ӨГӨГДЛИЙГ БҮРДҮҮЛЭХ

Жендэрийн тэгш байдал нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг ойлгох, улмаар тэдний боломжийг адил тэгш болгох тухай ойлголт тул тэрхүү ялгаатай хэрэгцээ, нөхцөл байдлыг хэр тодорхой хэмжиж чадна тэр хэмжээгээр оновчтой бодлогын шийдлээр дэмжих боломжтой.

Бизнесийн салбарт хүйсээр ангилсан өгөгдлийг цаашид нарийвчлан бүрдүүлэх шаардлага байсаар буй. Ялангуяа бизнесийн салбарын холбоотой өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэгч байгууллагууд, тухайлбал, ҮСХ, Монголбанк, ЖДҮГ, ТЕГ, Санхүүгийн зохицуулах хороо, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан зэрэг төрийн байгууллагууд болон арилжааны банкууд өөр өөрийн үйл ажиллагааны хүрээнд хүйсээр ангилсан бизнесийн өгөгдлийг бүрдүүлж ирсэн ч эдгээр нь аргачлал, тодорхойлолтын хувьд ялгаатай байдаг тул нэгдсэн байдлаар хүйсээр ангилсан өгөгдлийн сан болгон ашиглахад хүндрэл тулгардаг. Үүний хамгийн

том нэг шалтгаан нь бизнес эрхлэгчийн хүйсээр ангилсан тодорхойлолт байхгүй, байгууллага бүр өөр өөрийн тодорхойлолтыг ашиглаж ирсэн явдал юм. Тиймээс бизнес эрхлэлтийн хүйсээр ангилсан нэгдсэн, үнэн зөв мэдээлэл бүрдүүлэхийн тулд эрэгтэй, эмэгтэй, цаашлаад бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчийн ойлгомжтой, яв цав тодорхойлолт бий болгох шаардлагатай.

Түүнчлэн бизнесийн цар хүрээ тэлэлт болон карьер өсөлтийн хурдыг хүйсийн ялгаатай хэмжсэн нарийвчилсан судалгаа, өгөгдөл, түүнд тохирсон бодлого бизнесийн салбарт үгүйлэгдэж байна.

4. ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ

Жендэрийн тэгш байдал нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг тэгш тоотой оролцуулах тухай бус сонголт хийх тэгш боломжоор хангаж, ялгаатай хэрэгцээг харгалзсан шаардлагатай бодлого хэрэгжүүлэх замаар эрэгтэй, эмэгтэй хүйсийн оруулах хувь нэмэр хийгээд хүртэх үр ашгийг тэнцвэржүүлэх тухай асуудал юм.

Ялгаатай хэрэгцээг таних нь эхний алхам бөгөөд ялгаатай хэрэгцээг ойлгож, чиглэсэн бодлого хэрэгжүүлэх нь гол анхаарах чиглэл юм.

Бизнесийн салбарт ч жендэрийн онцлог ялгаанууд оршиж буй тул тэдгээрийг харгалзан авч үзсэн чиглэсэн бодлого тодорхойлох нь зайлшгүй шаардлага юм. Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 5.2-т заасан төрийн бодлогын хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүний нийгэм, гэр бүлийн харилцаанд үүссэн тэгш бус байдлыг арилгах, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн тусгай арга хэмжээ хэрэгжүүлэх бөгөөд эдгээр тусгай арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй” гэж заасан байдаг.

5. БИЗНЕСИЙН САЛБАР ДАХЬ ЖЕНДЭРИЙН БУРУУ ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТЫГ ЗАСАХ

Бизнес манлайллын нүүр царай эрэгтэй хүйсээр тодорхойлогдож буй жендэрийн буруу хэвшмэл ойлголтыг засах, соён гэгээрүүлэх ажил хийх шаардлага бий. Монгол Улсын жендерийн тэгш байдлыг бий болгоход саад болж буй нэгэн том асуудал бол соёлын элементүүд гэж үзэж байна. Соёлын элементүүдийн хохирогч нь ихэвчлэн эмэгтэйчүүд байдаг. Хөрөнгө эзэмших, бизнес эзэмших, бизнес эрхлэх, бизнесээ томруулах зэрэгт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс хоцорч байгаа нь соёлын элементүүдийн нөлөөллийн нэг илрэл гэж харж болохоор байна. Тиймээс бизнес эрхлэлт болон соёлын элементүүд хоорондын харилцан хамаарлыг нарийвчлан судлах, хэвшмэл буруу ойлголтыг засах, арилгах шаардлагатай.

Нийгмийн зүгээс оноосон жендэрийн үүрэг, хариуцлага, дүр нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн өмнө нээгдэх боломжийг ялгаатай болгож улмаар тэгш оролцох боломжийг хаадаг.



ISBN 978-9919-9907-3-2



9 789919 990732